

ШУТИС-ИЙН БАГШИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

**УЛААНБААТАР ХОТ
2021 он**

АГУУЛГА

УДИРТГАЛ

НЭГ. ПРОФЕССОР БАГШИЙН ЧАДАМЖИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ЧИГ ХАНДЛАГЫН СИСТЕМИЙН ШИНЖИЛГЭЭ

- 1.1 Профессор багшийн чадамжийн өнөөгийн нөхцөл байдлын SWOT шинжилгээ
- 1.2 ШУТИС-ийн багшийн хөгжлийн талаарх эрх зүйн болон макро болон микро орчны PEST шинжилгээ
- 1.3 Багшийн хөгжлийг дэмжиж буй олон улсын туршлага
- 1.4 Хөтөлбөр боловсруулах нийтлэг үндэслэл

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, САНХҮҮЖИЛТ

- 2.1 Хөтөлбөрийн зорилго, зорилт
- 2.2 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим
- 2.3 Хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөлт
- 2.4 Хөтөлбөрийн удирдлага, санхүүжилт

ГУРАВ. БАГШИЙН УР ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ, ДЭМЖИХ

- 3.1 Профессор багшид тавигдах нийтлэг шаардлага
- 3.2 Профессор багшийн чадамж, үнэлгээ
- 3.3 Багшийн цогц чадамжийг дэмжих сургалтын төлөвлөгөө
- 3.4 Багшийн хөгжлийн хувийн төлөвлөгөө

УДИРТГАЛ

Сүүлийн жилүүдэд Монгол улсын Засгийн газраас дээд боловсролын сургалтын байгууллагын багшийн хөгжлийг дэмжих чиглэлээр хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэхэд ихээхэн анхаарч ажилласан байна. Үүнд:

1. Монгол улсын дээд боловсролын салбарын хөгжлийн бодлого нь НҮБ-аас дэвшүүлсэн Тогтвортой хөгжлийн 17 зорилгын Чанартай боловсролыг тэгш, хүртээмжтэй хүргэх 4 дэх зорилго, Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа - 2050”, Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Боловсролын талаар төрөөс баримтлах бодлоготой уялдаж, мэдлэгт суурилсан нийгмийг байгуулах ур чадвар бүхий Монгол хүнийг төлөвшүүлэх, тогтвортой хөгжлийн зорилтыг хангахад чиглэсэн тогтолцоог хөгжүүлэх, боловсронгуй болгоход чиглэсэн дээд боловсролын үр дүнтэй тогтолцоог бий болгохыг зорьсон байна.
2. Их сургуулиудын тогтвортой хөгжлийн нэг үндсэн нөхцөл нь Багшийн хөгжил болохыг Тогтвортой хөгжил, дээд боловсрол улсын II зөвлөгөөнд “Багшийн хөгжлийг хангах нь их сургуулийн тогтвортой байдал болон гадаад, дотоод хамтын ажиллагааг нэмэгдүүлж, боловсролын чанарыг баталгаажуулж, багш нарын мэдлэг, ур чадвар, чадавхыг бэхжүүлж, их сургуулийн бие даасан, тэнцвэртэй хөгжлийг бататгахад оршино” гэж онцлон тодорхойлсон.
3. Монгол Улсын их хурлын 2016 оны 45 дугаар тогтоолын 3.2.25-д “Шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын хүний нөөцийг хөгжүүлэх бодлого баримтална” гэж заасан.
4. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 282 тогтоолоор баталсан “Судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 4-р зорилтын хүрээнд “шинжлэх ухаан, технологи, инновацын хөгжлийн орчин үеийн тэргүүлэх чиглэлээр нарийн мэргэшсэн чадварлаг эрдэмтэн, судлаачдыг судалгаанд суурилсан их сургуулиудад төвлөрүүлэх” замаар ахисан түвшний сургалт, судалгааг хөгжүүлэхээр дэвшүүлсэн.
5. Монгол Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар 27-ны өдөр баталсан Багшийн хөгжлийг дэмжих хуулийн 7.1-д “Бүх шатны боловсролын сургалтын байгууллага нь багшийн хөгжлийн төвтэй байхаар”, хуулийн 7.4-т “Дээд боловсролын сургалтын байгууллага нь багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагаанд зарцуулах зардлын хэмжээг тухайн сургуулийн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж, батлуула”

гэж тус тус заасан нь төрөөс багшийн хөгжлийг дэмжих чиглэлээр хууль, эрх зүйн орчин, бодлого төлөвлөлтийг бүрдүүлэхэд анхаарч ажилласныг харж болохоор байна.

Монгол улсын шинжлэх ухаан, технологийн хүний нөөцийг бэлтгэх, улс орны өмнө тулгамдсан асуудлуудыг шийдэх эрдэм шинжилгээ, судалгаа, инновацын ажлыг гүйцэтгэхэд тэргүүлэх байр суурь эзэлдэг их сургуулийн хувьд ШУТИС нь Багшийн хөгжлийн асуудлыг чухалд тооцоор ирсэн. Тухайлбал, 2020-2030 онд их сургуулиа хөгжүүлэх ШУТИС-2030 стратеги төлөвлөгөөнд тусгасан урт хугацааны үндсэн зорилго болох Дэлхийн шилдэг 1000 их сургуулийн нэг болоход гол үүрэгтэй манлайлж оролцох профессор, багш нарын хөгжлийн асуудлуудыг тусгасан зорилго, зорилтууд тэдгээрт хүрэх арга зам, шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлж оруулсан. Мөн дээд боловсролын салбарт явагдаж буй парадигмын шилжилт, өөрчлөлтүүд нь их сургуулийн багшийн ажлын байрны тодорхойлолт, үүрэг хариуцлага, ур чадвар болон чадамж, багшид тавигдах нийтлэг шаардлага, багшийн ёс зүй, багшийн үнэлгээ урамшууллын механизм, багшийг хөгжүүлэх сургалтын систем, карьер хөгжил зэргийг эргэн харж багшийн хөгжлийн хөтөлбөрийг сайжруулах бус цоо шинээр боловсруулах шаардлагыг бий болгож байгаа тул “ШУТИС-ийн Багшийн хөгжлийн хөтөлбөр” бодлогын баримт бичгийг боловсруулсан юм.

НЭГ. ПРОФЕССОР БАГШИЙН ЧАДАМЖИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ЧИГ ХАНДАГЫН СИСТЕМИЙН ШИНЖИЛГЭЭ

2021 оны байдлаар ШУТИС-д нийт 984 профессор, багш нар ажиллаж байгаа бөгөөд нийт багшид доктор цолтой багшийн эзлэх дундаж хувь ШУТИС-ийн хэмжээнд 44.6% байна. Албан тушаалын ангиллаар авч үзвэл зөвлөх профессор 21 (2.2%), профессор 42 (4.3%), салбар, тэнхимийн эрхлэгч 47 (4.9%), дэд профессор 92 (9.5%), ахлах багш 368 (38.1%), багш 397 (39.5%), дадлагажигч багш 17 (1.5%) байна.

ШУТИС-ийн хэмжээнд Багшийг дэмжих үйл ажиллагааны нийт зардлыг сүүлийн 5 жилийн гүйцэтгэлээр нь авч үзвэл 2016 онд 557.4 сая, 2017 онд 326.2 сая, 2018 онд 372.2 сая, 2019 онд 277.2 сая, 2020 онд 59.1 сая төгрөг болж жил бүр буурсан үзүүлэлттэй байна.

1.1 Профессор багшийн чадамжийн өнөөгийн нөхцөл байдлын SWOT шинжилгээ

Өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийхдээ байгууллагын стратеги төлөвлөлтөд нийтлэг хэрэглэгддэг нөхцөл байдлын шинжилгээний арга зүйд тулгуурласан. Багшийн чадамжийн SWOT шинжилгээг дараах байдлаар хийв (Хүснэгт 1).

Хүснэгт 1. ШУТИС-ийн багшийн чадамжийн SWOT шинжилгээ

ДАВУУ ТАЛ	СУЛ ТАЛ
<ul style="list-style-type: none"> Багш нар шинжлэх ухааны тодорхой салбар, сургалтын хөтөлбөрийн дагуу мэргэшсэн. Гадаадад эрдмийн зэрэг хамгаалсан багшийн тоо нэмэгдэж байгаа. Багшлахуй, сургахуйн тодорхой мэдлэг, ур чадвар, туршлагатай багшлах хүний нөөц тодорхой хэмжээнд бүрдсэн. Багшийн чадамжийг суралцагчид үнэлэх чанарын менежментийн тогтолцоо бүрдэж байгаа Багш нар нь өөрийн гэсэн эрхэмлэх үнэт зүйлтэй. Мэргэжлийн болон хувь хүний тодорхой ур чадваруудыг эзэмшсэн. Нийгмийн болон мэргэжлийн чиглэлээр сайн үйлийг тодорхой хэмжээнд хийдэг багш нар бий болсон. Сургалт судалгааны ажлыг хөтлөн явуулах тодорхой чадвартай профессор багш нар олон байна. 	<ul style="list-style-type: none"> Сургалт, судалгааны тэнцвэрт харьцаа алдагдсан, сургалт, бусад ажил үйлчилгээ хэт давамгайлснаас бие даасан судалгаа, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, судалгааны ажилд зарцуулах цаг хомс байна. Багшийн хөгжлийн талаарх ойлголт шинэчлэгдээгүй, сургалт, семинар төдийхнөөр ойлгож, үнэлдэг. Багшийн чадамжийг үнэлэх үнэлгээний нэгдсэн систем тогтолцоо бүрдээгүй. Үндэсний хэмжээнд баримтлах багшийн чадамжийн хүрээ байхгүй. Улсын хэмжээнд их, дээд сургуулийн багшид тавигдах нийтлэг шаардлага тавигдаагүй. Багшийн статус, хөдөлмөрийн үнэлгээ, албан тушаал дэвших боломж, нэр хүнд, нийгмийн үнэлэмж шаардлага нь харилцан адилгүй байгаа.
БОЛОМЖ	ЭРСДЭЛ
<ul style="list-style-type: none"> Багшлах хүний нөөц харьцангуй залуу байгаа нь сургахуй, багшлахуйн үйлд мэдээллийн технологийн ололтыг олон хувилбараар ашиглах боломжтой. Багшийн хөгжилд багш өөрөө манлайлж, судалгаа, инновацыг бүтээгч байж, түүгээр дамжуулан сургалт, хөтөлбөрт шинэ технологи нэвтрүүлэх, багшийн орлого, ашгийг өсгөх. Багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд шинэчлэл хийж шинэ систем нэвтрүүлэх. Багшийн чадамжийн нийтлэг шаардлага гаргах, ажлын үнэлгээг боловсронгуй болгох, судлаач-багш болох орчин нөхцөлийг бүрдүүлэх. Багшийн хөгжих дотоод сэдэл тэмүүллийг бий болгож, хадгалах, тэдний нэр хүнд, байр суурь, цалин урамшууллыг нэмэгдүүлэх. Шийдвэр гаргах, хэрэгжилтийг үнэлж, дүгнэхэд багш нарын бүтээлч оролцоог хангах механизмыг бүрдүүлж хэрэгжүүлэх. 	<ul style="list-style-type: none"> Багшийн шинжлэх ухааны хандлага, цэгцэрсэн сэтгэлгээ, ёс зүйн төлөвшил, авьяас, ур чадварын зарим талын дутагдалтай байдал. Багшийн хөгжлийг дэмжих санхүүгийн болон бусад нөөцийн хязгаарлагдмал байдал. Багшийн эрдэм шинжилгээ, судалгаа, инновац бүтээх үүрэг нэмэгдэж, тэдний дунд ажлын байрны бодит өрсөлдөөн бий болно. Гадаад хэлний мэдлэгийн түвшин өнөөгийн шаардлагад төдийлэн хүрэхгүй байгаа.

Нөхцөл байдлын SWOT шинжилгээний үр дүнгээс дараах дүгнэлтийг хийж болохоор байна. Үүнд:

- ✓ ШУТИС нь тухайн хөтөлбөрийн дагуу мэргэшсэн оюутнуудад мэдлэг, ур чадвар олгох туршлагатай хүний нөөцтэй.
- ✓ Сүүлийн жилүүдэд гадаадад эрдмийн зэрэг хамгаалсан багшийн тоо нэмэгдэж байгаа.
- ✓ Багшийн чадамжийг хамт олон болон суралцагчид нь үнэлэх чанарын менежментийн тогтолцоо бий болж байна.
- ✓ Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зарцуулах цаг хомс учраас эрдмийн зэрэгтэй багш нарын тоо бага байгаа бөгөөд судалгааны чадамжийг нэмэгдүүлэх, инновац, шинэ бүтээл гаргах үйлд суралцах, хэрэгжүүлэх хэрэгтэй байна.
- ✓ Багшийн чадамжийн хүрээ, багшид тавигдах нийтлэг шаардлага тавигдаагүй нь багшийн үнэ цэн, багшийн статус, хөдөлмөрийн үнэлгээ, албан тушаал дэвших боломж зэрэг нийгмийн үнэлэмж нь хангагдаагүй байгааг илэрхийлж байна.
- ✓ Технологийн дэвшил хөгжил, хиймэл оюун ухааны шилжилтийн өнөө үед ажиллах мэдлэг, ур чадварт багш нарын олонх системтэй суралцаж бэлтгэгдээгүй, багшийн шинжлэх ухааны хандлага, системийн сэтгэлгээ, ёс зүйн төлөвшил, авьяас, ур чадвар зарим талаараа дутагдалтай байгаа нь цаашид эрсдэл дагуулах хандлагатай байгааг анхаарч энэ талаар бодлого, дэмжлэг хэрэгтэй байна.

1.2 Багшийн хөгжил, чадамжид хийсэн PEST чиг хандлагын шинжилгээ

Их, дээд сургуулийн сургалтын үйл ажиллагааны үр дүн нь суралцаж буй оюутнуудын тоо, суралцагчийн сэтгэл ханамжийн үнэлгээ, суралцагчийн голч дүн зэрэг тоон болон чанарын үзүүлэлтээр үнэлэгддэг. Иймд сургалтын үйл ажиллагааг удирдан зохион байгуулдаг багшлах боловсон хүчний чадамжийн өнөөгийн түвшинг тодорхойлох зорилгоор PEST (Political, Economic, Sociological, Technological) шинжилгээг хийлээ (Хүснэгт 2).

Хүснэгт 2. ШУТИС-ийн багшийн чадамжийн PEST шинжилгээ

УЛС ТӨРИЙН ХҮЧИН ЗҮЙЛС	ЭДИЙН ЗАСГИЙН ХҮЧИН ЗҮЙЛС
<ul style="list-style-type: none"> • Багшийг үнэлэх үнэлгээний шалгуур, аттестатчилал хийх бие даасан журмууд байна. • Багшийг хөгжлийг дэмжих чиглэлээр төрийн бодлогыг баримталдаг. • Багшийн чадамжийн хүрээг боловсруулсан. • Багшийн чадамжийг дээшлүүлэх чиглэлээр гадаад дотоодын хамтын ажиллагааг дэмждэг тогтолцоо тогтвортой, сайн ажиллахгүй байгаа. 	<ul style="list-style-type: none"> • Судалгаа, төсөл хөтөлбөрт оролцдог багш жилд дунджаар цалингаас гадна 1.0–4.5 сая төгрөг хүртэлх орлого олох боломжтой. • ДБСБ-ийн багш хоногт дунджаар 10-12 цаг зарцуулан ажилладаг. • Багшийн албан тушаалын зэрэглэлээр цалингийн зөрүү бага байдаг. • Багшийн ур чадварын нэмэгдэл байхгүй.
НИЙГМИЙН ХҮЧИН ЗҮЙЛС	ТЕХНОЛОГИЙН ХҮЧИН ЗҮЙЛС
<ul style="list-style-type: none"> • Цалингийн шагналыг багшийн ур чадвар, бүтээмжтэй шууд холбож үздэггүй голлож ажилласан жилээр тогтоодог нь хөгжих, өсөж дэвших хөшүүрэг болж чадахгүй байна. • Багшийн нийгмийн сайн сайхны төлөөх үйл нь хязгаарлагдмал, түүнийг дэмжих хөшүүрэг байхгүй. • Багшийн нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд багшийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх нэгдсэн тогтолцоо байхгүй. 	<ul style="list-style-type: none"> • Багшийн шинэ технологи эзэмших боломж, арга зүй, тогтолцооны хувьд учир дутагдалтай. • Багшид сургалт болон судалгаа хийхэд нь зориулсан лицензтэй программ хангамжийн бүрдүүлэлт маш муу. • Багш бүрд ашиглах, ажиллах техник хэрэгсэл, технологийн хангамж сайн бүрдээгүй.

Профессор, багшийн чадамжийн өнөөгийн нөхцөл байдалд хийсэн SWOT, PEST шинжилгээний үр дүнд дараах дүгнэлтийг хийж болно. Үүнд:

1. Багшийг үнэлэх үнэлгээний шалгуур, аттестатчилал хийх бие даасан журамтай хэдий ч үнэлгээний аргачлалыг шинэчлэх шаардлагатай.
2. Багшийн чадамжийг дээшлүүлэх чиглэлээр гадаад, дотоодын хамтын ажиллагааг тогтвортой дэмждэг тогтолцоогүй.
3. Багшийн цагийн үнэлэмж дэлхийн бусад орнуудтай харьцуулахад хэтэрхий бага байгаа бөгөөд өндөр чадамжтай багшийн нөөцийг бүрдүүлэхэд саад болж байна.
4. Багшийн цагийн болон оюуны ачаалал өндөр, тасралтгүй хөгжил, сайжруулалтыг шаарддаг, олон салбар шинжлэх ухааны өргөн хүрээний мэдлэг, ур чадварыг шаарддаг учраас багшийн хөдөлмөрийн цагийг хуульд заагдсан хөдөлмөрийн цагаар хэмжих боломжгүй байдаг.
5. Их, дээд сургуулийн багш нь үйлдвэрлэл, нийгэмд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, судалгааны үр дүнгээрээ инновацийн бүтээл гаргах, үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломж хязгаарлагдмал байгаагаас тэдний бүтээлч сэтгэлгээ, судалгааны чадамжийг хөхүүлэн дэмжих их, дээд сургууль-үйлдвэрлэгч-төрийн гурвалсан бодлогоор дэмжиж, багшийн нийгэмд манлайлах чадамжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Иймд багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг эрчимжүүлэх, төсөв хөрөнгийн боломжид тулгуурлан үр дүнтэй, өгөөжтэй үйл ажиллагааг зохион байгуулах шаардлага тулгарч байна.

1.3 Багшийн хөгжлийг дэмжиж буй олон улсын туршлага

Олон улсад багшийг хөгжүүлэх бодлого нь багшийн хөгжил чадамжийн хүрээ, стандарттай салшгүй холбоотой байдаг байна. ШУТИС-ийн багшийн чадамжийн хүрээ, тавигдах нийтлэг шаардлага боловсруулах талаарх судалгаанаас харахад дэлхийн хөгжингүй зарим орнууд нь багшийн чадамжийн хүрээ, стандартыг гарган мөрдөн ажилладаг байна. Тухайлбал, Англи улс нь “Дээд боловсролын багшлахуй, суралцахуйг дэмжих мэргэжлийн стандарт хүрээ” (The UK Professional Standards Framework for Teaching and Supporting Learning in Higher Education)-г мөрддөг бол Нидерландад “Дээд боловсролд багшлах чадамжийн хүрээ” (Framework for Teaching Competencies in Higher Education), Бельги улс нь “Дээд боловсролын оюутан төвтэй багшлахуйн чадамжийн хүрээ”-г (Competence Profile for the Role of Student-centred Teachers in Higher Education, Belgium) тус тус баримталдаг. Түүнчлэн дэлхийн судалгааны их сургуулиудын нэгдсэн “U21 Багшлахуйн стандартын хүрээ” (U21 Teaching Standards Framework)-г гаргаж хэрэгжүүлдэг байна. Дээрх орнуудын гаргасан багшийн мэргэжлийн хүрээ, стандартуудыг судалж үзэхэд багшийн мэргэжлийн хөгжлийн хүрээ нь хоорондоо харилцан уялдаа бүхий дараах нийтлэг гурван хэсэгт хувааж үздэг байна. Үүнд:

- 1) Хувь хүний болон мэргэжлийн үнэ цэн, хандлага,
- 2) Багшийн мэргэжлийн ур чадвар,
- 3) Багшийн мэдлэг зэрэг болно.

Багшийн хувь хүний болон мэргэжлийн үнэ цэн нь тухайн улсын мэргэжлийн хөгжлийн хүрээтэй шууд холбоотой бөгөөд сургуулийн өмнөх боловсролоос эхлээд их сургуулийн багш хүртэлх эзэмшсэн хувь хүний төлөвшил, хүмүүжил, хандлагаар тодорхойлогддог байна. Харин багшийн мэргэжлийн ур чадвар нь сурган хүмүүжүүлэх ур чадвараас гадна эзэмшсэн тухайн мэргэжлийн ур чадвар хамрагдана. Багшийн үндсэн мэдлэгт тухайн хувь хүний мэргэжлийн болон нийтлэг мэдлэгийн цар хүрээ багтана.

Олон улсад их, дээд сургуулийн багшийг хөгжүүлэх бодлого нь ихэвчлэн багшлахуй, сургахуйн чадварыг сайжруулахад чиглэгдсэн байна. Тухайлбал, Европын холбооны Erasmus

төслийн санхүүжилтээр European Forum for Enhanced Collaboration (Teaching (EFFECT) хийсэн төслийн хүрээнд 28 орны дээд боловсролын тогтолцоонд багшлахуй, сургахуйн чадварыг сайжруулахад чиглэгдсэн бодлого, хөтөлбөр болон бусад эрх зүйн баримтуудыг судалсан байна. Уг судалгааны үр дүнгээс харахад төслийн хүрээнд оролцсон 28 орны дөнгөж 4 нь буюу 14.0 хувь нь багшлахуйн суралцахуйн талаар үндэсний стратеги юмуу багшлахуйн хүрээтэй байдаг. Үүнд: Австри, Ирланд, Нидерланд, Норвеги улсууд юм. Харин 15 орон буюу 54 хувь нь сургахуй, багшлахуйд зориулсан бодлого нь дээд боловсролын стратеги эсвэл бусад стратегийн бодлогын баримт бичгийн нэг хэсэг нь болдог байна. Үүнд: Болгар, Хорват, Кипр, Чех, Финлянд, Франц, Унгар, Итали, Израиль, Казахстан, Литва, Польш, Словак, Испани, Их Британи (Англи). Бусад 9 улс буюу 32 хувь нь сургахуй, багшлахуйн стратеги, санал санаачилга одоогийн байдлаар байхгүй байна. Үүнд: Дани, Эстон, Гүрж, Герман, Грек, Латви, Португали, Словени, Швед орнууд юм (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Багшийн хөгжлийн бодлого, стратегийн талаарх олон улсын судалгаа

д/д	Дээд боловсролын систем	Сургахуй, багшлахуйн үндэсний стратеги, бодлогын хүрээ	Багшийн хөгжлийг дэмжих бодлого, зохицуулалт	Багшлах ур чадвар нь карьер хөгжилд тооцогддог эсэх	ДБ-ын үндэсний сургахуйн шагнал
1	Австри	<input type="checkbox"/>	-	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Болгар	-	-	-	-
3	Хорват	-	-	-	-
4	Кипр	-	-	-	-
5	Чех	-	-	-	-
6	Дани	-	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	-
7	Эстон	-	-	-	<input type="checkbox"/>
8	Финлянд	-	<input type="checkbox"/>	-	-
9	Франц	-	<input type="checkbox"/>	-	<input type="checkbox"/>
10	Гүрж	-	<input type="checkbox"/>	-	-
11	Герман	-	-	-	<input type="checkbox"/>
12	Грек	-	-	-	<input type="checkbox"/>
13	Унгар	-	-	-	-
14	Ирланд	<input type="checkbox"/>	-	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
15	Израиль	-	-	-	<input type="checkbox"/>
16	Итали	-	-	-	-
17	Казахстан	-	-	-	<input type="checkbox"/>
18	Латви	-	<input type="checkbox"/>	-	<input type="checkbox"/>
19	Литва	-	<input type="checkbox"/>	-	-
20	Нидерланд	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
21	Норвег	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
22	Польш	-	-	-	<input type="checkbox"/>
23	Португаль	-	-	-	-
24	Словак	-	-	-	<input type="checkbox"/>
25	Словени	-	-	-	<input type="checkbox"/>
26	Испани	-	-	-	-
27	Швед	-	-	<input type="checkbox"/>	-
28	Англи	-	-	-	<input type="checkbox"/>
	Нийт	4	8	6	15

Дээрх хүснэгтээс харахад судалгаанд оролцсон гадаад орнуудын дээд боловсролын салбарт багшийн хөгжлийг дэмжих талаарх бодлого, стратеги, урамшуулал тогтолцоо бүхий тогтсон системтэй болохыг харж байна. Энэ нь ДБСБ-ын багшийн хөгжлийг зөвхөн өөрийн мэргэжлийн мэдлэг, ур чадварын хүрээнд бус харин сургахуйн, багшлахуйн чиглэлээр илүүд анхаарч тасралтгүй хөгжихөд нь төрөөс дэмжлэг үзүүлдэг болох нь харагдаж байна.

Хүснэгт 4 . Олон улсын багшийн хөгжлийн бодлого, системийн байдал

д/д	Улс орон	Багшийн хөгжлийн бодлого, тогтолцооны систем
1.	Австри	Энэ чиглэлээр тодорхой стратеги байхгүй боловч харин цуврал санаачилга, ажлын хэсэг гэж хүлээн зөвшөөрөгдсөн багшлахуй, сургахуйн бодлогын хүрээг гаргасан.
2.	Ирланд	Дээд боловсролын эрх бүхий байгууллага нь багшлахуй, сургахуйг сайжруулах үндэсний форумыг байгуулсан. Уг форум нь бүх дээд боловсролын байгууллагуудад суралцахуй, багшлахуйн туршлагыг дэмжиж, суралцах туршлагын чанарыг сайжруулах зорилготой бүх оюутнуудыг 2030 он хүртэлх Дээд боловсролын үндэсний стратегийн үндсэн зорилтуудад нийцүүлсэн. Дижитал чадамжийг нэмэгдүүлэх бүдүүвч (The Development of a Roadmap for Digital Capacity), дээд боловсролд багшилж буй бүх ажилчдад зориулсан мэргэжлийн түвшний хөгжлийн үндэсний хүрээ (National Professional Development Framework), 10-ыг бэхжүүлэх зэрэг чиглэлүүд багтаж нотлох баримт ба сахилгын болон сурган хүмүүжүүлэх сүлжээг баримталдаг байна. Түүнчлэн энэ чиглэлээр багшийг урамшуулах тогтолцоотой (The development of National Learning Impact Awards).
3.	Нидерланд	2015 онд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам "2015-2025 оны Мэдлэгийн үнэ цэнэ, Дээд боловсрол, Судалгааны Стратегийн Хөтөлбөр" гарган хэрэгжүүлж байгаа.
4.	Норвеги	2017 оны 1-р сард Боловсрол, Судалгааны Яам "Дээд Боловсролын Чанарын Соёл" нэртэй төслийг Парламентад өргөн барьсан.
5.	Болгар, Хорват, Кипр, Бүгд найрамдах Чех, Финлянд, Франц, Унгар, Итали, Изриал, Казакстан, Литва, Польш, Словак, Их Британи	Дээд боловсролд зориулсан стратеги эсвэл бусад стратегийн баримт бичгийг нэг хэсэг болгосон суралцахуй, багшлахуйн стратегитай байдаг. Эдгээр стратегиуд нь дээд боловсролын сургалтын чанарыг сайжруулах, оюутан төвтэй сургалт гэх мэт ерөнхий зорилго бүхий сургахуй, багшлахуйн хэсгийг хамардаг.
6.	Дани, Франц, Гүрж, Латви, Нидерландын улсууд, Норвеги.	Тодорхой стратеги бодлого байхгүй харин багшлахуйн чадварын сайжруулахыг үндэсний хэмжээнд хянадаг.

1.4 Хөтөлбөр боловсруулах нийтлэг үндэслэл

ШУТИС-ийг 2030 он хүртэл хөгжүүлэх стратеги төлөвлөгөөнд хүний нөөцийн чадавхийг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор “Тэргүүлэх чиглэл 1. Суралцахуйн шинэчлэл ба карьер хөгжил”-д

1.3. Сургалтын үйл ажиллагаанд инновац нэвтрүүлнэ.

1.4. Судалгаа болон үр дүнд суурилсан сургалтыг эрчимжүүлнэ.

1.5. Багш судлаачийг өөрийгөө тасралтгүй хөгжүүлэхэд дэмжлэг тогтолцоог бүрдүүлэх зэрэг зорилтуудыг дэвшүүлэн тавьсан.

Багшийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулах хэрэгцээ шаардлага, нийтлэг үндэслэлийг гаргахын тулд олон улсын болон Монгол улсын дээд боловсролын салбарт явагдаж буй дараах өөрчлөлт шинэчлэл, парадигмын шилжилтүүдийг нухацтай авч үзэх нь зүйтэй. Үүнд:

1. Багшлахуйгаас суралцахуйд шилжих шилжилт: Их дээд сургуулийн багш нь уламжлалт хичээл заах хэлбэрээс сурах үйл ажиллагааны дизайнер болж өөрчлөгдөх парадигмын шилжилт олон улсад явагдаж байна.
2. Багшлахуйгаас судлахуйд шилжих шилжилт: Монгол улсын дээд боловсролын систем нь оюутнууддаа сургах заах, өөрөөр хэлбэл сургалтын үйл ажиллагааг голлон явуулж ирсэн. Монгол улсын засгийн газраас “Судалгааны их сургууль” үндэсний хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж эхэлснээр их, дээд сургууль нь судалгааны их сургууль болж хөгжих шилжилтийг хурдасгалаа. Иймд их, дээд сургуулийн багш нь судлаач байх шаардлагатай хийгээд судалгааны ур чадвараа тасралтгүй сайжруулах зайшгүй шаардлага тулгарч байна.
3. Хөтөлбөрийн хөгжүүлэлт, өөрчлөлт, шинэчлэл: Аж үйлдвэрийн 4-р хувьсгал түүнтэй холбоотой ирээдүйн ажлын байрны өөрчлөлт, Z-үеийнхний шаардлагаар технологид суурилсан суралцахуйн хэв шинж зэрэг технологийн хурдацтай хөгжилтэй уялдсан олон

хүчин зүйл боловсролын хөтөлбөрүүдийг эрс шинжлэх, дижитал шилжилт хийхэд хүргэж байна. Тиймээс дижитал ур чадвар сайтай, ирээдүйн хөдөлмөрийн зах зээл, ажлын байранд тавигдах шаардлагуудыг хангахуйц мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрүүдэд нийцсэн дижитал болон бусад ухаалаг технологид суурилсан сургалтыг загварчлан хэрэгжүүлэгч багшийг хөгжүүлэх зайлшгүй шаардлага байна.

4. Их сургуулийн үүрэг хариуцлагын өөрчлөлт: Өнгөрсөн хугацаанд их, дээд сургуулийн үүрэг хариуцлага нь улс орны хөгжилд нэн шаардлагатай хүний нөөцийг бэлтгэх байсан бол цаашид их, дээд сургууль нь улс орны нийгэм, эдийн засагт хувь нэмэр оруулах судалгаа, инновацыг бий болгож эргэлтэд оруулах, тогтвортой хөгжлийн зорилтыг хангаж мэдлэгт суурилсан нийгмийг цогцлоох үндсэн хөшүүрэг болж хөгжих шаардлага тулгарлаа. Иймд их, дээд сургуулийн багш нь дан ганц сургалт, судалгааны үйл ажиллагаа хийгээд зогсохгүй мэдлэгийг бүтээх, зах зээлийн эргэлтэд оруулах, нийгэмд чиглэсэн соён гэгээрүүлэх үйл явуулах, аж үйлдвэрийн хөгжлийг дэмжих мэргэжлийн үйлчилгээг үзүүлж инновацын эко системийг бий болгох үндсэн хүний нөөц болж байна.
5. Нээлттэй боловсрол, дижитал суралцахуй, дижитал шилжилт: Дээд боловсролын салбарт явагдаж хамгийн чухал шилжилт бол дижитал шилжилт (Digital Transformation) юм. Боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх, чанарыг өсгөх, зардлыг бууруулах гол арга зам нь цахим сургалтыг хэрэгжүүлэх, нийтэд зориулсан нээлттэй хичээл (MOOC) -ийг хөгжүүлэх, сургалтын нээлттэй нөөц эх материал (OER), цахим контентыг олноор бэлтгэж ашиглах явдал болж байна. Дэлхий нийтээрээ тогтвортой хөгжлийн 4-р зорилгыг хангах гол арга зам бол нээлттэй боловсролыг хөгжүүлэх, тэр дундаа MOOC хичээлийг хөгжүүлэх гэдгийг хүлээн зөвшөөрч байна. Тиймээс их, дээд сургуулийн багш нь танхимын, онлайн, хосолсон сургалтуудыг үр дүнтэй явуулах чадвартай, дижитал контент, онлайн хичээлийг бэлтгэж ашиглах арга барил эзэмшсэн байх шаардлагатай.

Дээд боловсролын салбарт явагдаж буй эдгээр парадигмын шилжилт, өөрчлөлтүүд нь их сургуулийн багшийн ажлын байрны тодорхойлолт, үүрэг хариуцлага, ур чадвар болон чадамж, багшид тавигдах нийтлэг шаардлага, багшийн ёс зүй, багшийн үнэлгээ урамшууллын механизм, багшийг хөгжүүлэх сургалтын систем, карьер хөгжил зэргийг эргэн харж багшийн хөгжлийн хөтөлбөрийг сайжруулах бус цоо шинээр боловсруулах шаардлагыг бий болгож байгаа юм.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, САНХҮҮЖИЛТ

2.1. Хөтөлбөрийн зорилго, зорилт

Нөхцөл байдлын болон чиг хандлагын шинжилгээнд суурилан багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд баримтлах зарчим, багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн зорилго, зорилтуудыг томъёоллоо.

ЗОРИЛГО:

ШУТИС-2030 стратеги төлөвлөгөөний зорилго зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн профессор багшийн мэдлэг оюуны болон үнэт зүйлийн илэрхийлэл болох судалгаа инновацын, багшлахуйн, хувь хүний манлайлал чадварын цогц чадамжийг тасралтгүй хөгжүүлэх үйл ажиллагааг дэмжихэд хөтөлбөрийн зорилго оршино.

Хөтөлбөрийн зорилгыг дараах зорилтуудаар хэрэгжүүлнэ. Үүнд:

Зорилт 1: Багшийн хөгжлийг дэмжих менежментийг төгөлдөржүүлнэ.

Зорилт 2: Багшлахуйн болон сургалтын технологийн ур чадварыг нийгэм, зах зээлийн эрэлттэй уялдуулан хөгжүүлнэ.

Зорилт 3: Профессор багшийн сургалт, судалгаа, инновацын ур чадварыг дэлхийн жишигт хүргэхэд дэмжлэг үзүүлнэ.

Зорилт 4: Профессор багшийн нийгмийн үйлчилгээ, хамтын ажиллагааны ур чадварыг бэхжүүлнэ.

Дээрх 4 үндсэн зорилтыг хэрэгжүүлэхийн тулд дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар төлөвлөсөн болно.

1. Багшийн хөгжлийг дэмжих менежментийг төгөлдөржүүлнэ.

- 1.1. Багшийн хөгжлийн талаарх олон улсын жишиг, чиг хандлагыг нээлттэй, уян хатан, тасралтгүй нэвтрүүлэх;
- 1.2. Багш мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх үйл ажиллагааг удирдан чиглүүлэх арга зүйч, сургагч багш нарыг бэлтгэн, ажиллуулах бодлогыг хэрэгжүүлнэ.

2. Багшлахуйн болон сургалтын технологийн ур чадварыг нийгэм, зах зээлийн эрэлттэй уялдуулан хөгжүүлнэ.

- 2.1 Багшлахуйн ур чадвар болон сургалтын шинэ дэвшилтэт арга, технологийг хэрэглэх ур чадварыг сайжруулна.
- 2.2 Багшийн цахим сургалт, хосолсон сургалт, нийтийг хамарсан нээлттэй онлайн хичээл зэрэг дэвшилтэт арга технологийн хэрэглээг нэмэгдүүлнэ.
- 2.3 Сургалтын хөтөлбөр боловсруулах, үнэлэх, хөгжүүлэх арга барилыг тасралтгүй дээшлүүлнэ.

3. Профессор багшийн сургалт, судалгаа, инновацийн мэдлэг, ур чадварыг дэмжинэ.

- 3.1.Багшийн судалгааны ур чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 3.2.Багш судалгааны ажлын үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, бойжуулах бизнес сэтгэлгээг нь хөгжүүлж, баялаг бүтээх манлайллыг хөгжүүлнэ.
- 3.3.Салбар мэргэжлийн тэнхимтэй хамтран төгсөгч, ажил олгогч нартай хамтран насан туршийн боловсрол, ур чадвар олгох сургалтуудыг зохион байгуулна.
- 3.4.Сургалт-судалгаа-үйлдвэрлэл буюу үйлдвэр ажил олгогчийн хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр сургалтын хөтөлбөрийн багуудтай хамтран ажиллана.

4. Профессор багшийн нийгмийн үйлчилгээ, хамтын ажиллагааны ур чадварыг бэхжүүлнэ.

- 4.1.Бүтээлч сэтгэлгээ, зөөлөн ур чадвар, ёс зүйтэй, хөрвөх чадвартай багшийн хөгжлийг дэмжинэ.
- 4.2.Нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, хүмүүнлэгийн болон сайн дурын үйл ажиллагаа явуулах сэтгэлгээг дэмжинэ.
- 4.3.Сургалт, судалгааны чиглэлээр салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах ур чадварыг дээшлүүлнэ.

2.2 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

- Хөтөлбөрийн бодлого, үйл ажиллагаа нь төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, үндсэн чиглэл, ШУТИС-ийн хөгжлийн зорилгуудтай нийцсэн байх;
- Багшийн хөгжлийн түвшин, эрэлт хэрэгцээ, сонирхол, боломж, итгэл үнэмшил, академик эрх чөлөө, бие даасан байдалд тулгуурлах;
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нээлттэй, хүртээмжтэй, хүний эрхийг хангах.

2.3 Хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөлт

Хүснэгт 5. Хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөлт

Үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх ажил	Хэрэгжүүлэх хэлбэр	Хүрэх үр дүн шалгуур	Хариуцан эзэн	Хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт (сая. Төг)				
					2022	2023	2024	2025	2026
I. Багшийн хөгжлийг дэмжих менежментийг төгөлдөржүүлэх зорилтын хүрээнд 2 үндсэн ажлыг хийнэ.									
1.1 Багшийн хөгжлийн талаарх олон улсын жишиг, чиг хандлагыг нээлттэй, уян хатан, тасралтгүй нэвтрүүлэх;	ОУ-ын Нээлттэй нийгэмлэгүүдийн сүлжээнд нэгдэж, контентуудыг судлах боломжийг бүрдүүлэх	Зөвлөн туслах	Хичээлдээ шинэ арга зүй, контент хэрэглэж буй багш нарын тоо	• Асуудал хариуцсан дэд захирал, НБТ	6.0	10.0	12.0	15.0	18.0
	ОУ-ын боловсролын платформ дээр хичээлүүдийг байршуулах, тэндээс хичээл судлах боломжийг бүрдүүлэх	Зөвлөн туслах	Хичээлдээ шинэ арга зүй, контент хэрэглэж буй багш нарын тоо	• Асуудал хариуцсан дэд захирал • НБТ, БС, Салбар, тэнхим	6.0	10.0	12.0	15.0	18.0
	Гадаадын ИДС-ийн онлайн сургалтанд багш нарыг хамруулах	Зөвлөн туслах	Хичээлдээ шинэ арга зүй, контент хэрэглэж буй багш нарын тоо	• Асуудал хариуцсан дэд захирал • НБТ	6.0	10.0	12.0	15.0	18.0
1.2 Багш мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх үйл ажиллагааг удирдан чиглүүлэх арга зүйч Сургагч багш нарыг бэлтгэн, ажиллуулах бодлогыг хэрэгжүүлэх	Бүрэлдэхүүн сургууль бүр дээр багшийн мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх үйлийг дэмжих	Зөвлөн туслах	Хичээлдээ шинэ арга зүй, контент хэрэглэж буй багш нарын тоо	• Асуудал хариуцсан дэд захирал • НБТ, БС, Салбар, тэнхим	10.0	15.0	20.0	20.0	20.0
	Сургалтын хөтөлбөрийг хөгжүүлэх арга зүйн багийг бүрэлдэхүүн сургуулиуд дээр байгуулан, арга зүйгээр тогтмол ханган ажиллах	Арга зүйн сургалт	Сургагч багш нараар дамжин хичээлийн арга зүйгээ шинэчилж буй багш, хичээл, хөтөлбөрийн тоо	• НБТ	10.0	15.0	20.0	20.0	20.0
Дүн, сая.төг					38.0	60.0	76.0	85.0	94.0
II. Багшлахуйн болон суралцахуйн ур чадварыг нийгэм, зах зээлийн эрэлттэй уялдуулан хөгжүүлнэ.									
2.1. Багшлахуйн ур чадвар болон сургалтын шинэ дэвшилтэт арга, технологийг хэрэглэх ур чадварыг сайжруулна.	Сургалтад шинэ дэвшилтэт арга, технологи, идэвхтэй сургалтын аргыг хэрэглэх ур чадварыг сайжруулах арга зүйгээр хангах	Зөвлөгөө, арга зүй, сургалт	Хичээд хэрэглэж буй дэвшилтэт арга технологи	• Асуудал хариуцсан дэд захирал • НБТ • ХЕХ, ХДХ	6.0	10.0	12.0	15.0	18.0
2.2. Багшийн цахим сургалт, хосолсон сургалт, нийтийг хамарсан нээлттэй онлайн хичээл зэрэг дэвшилтэт арга технологийн хэрэглээг нэмэгдүүлнэ.	Онлайн сургалт явуулах эрх зүйн орчин бүрдүүлж, хөгжүүлэхэд нь тусалж дэмжих	Зөвлөгөө, арга зүй, сургалт	Албан ёсны лицензтэй програм хангамжуудыг сургалтын үйл ажилагаанд нэвтрүүлж буй багшийн тоо	• Асуудал хариуцсан дэд захирал • НБТ, ХЕХ, ХДХ	6.0	10.0	12.0	15.0	18.0
	Онлайн сургалтын заах арга зүйг хэрэгцээнд нийцүүлэн шинэчлэхэд дэмжлэг үзүүлэх	Зөвлөгөө, арга зүй, сургалт	Хэрэглэж буй дижитал технологи, апп, тэдгээрийн тоо	• Асуудал хариуцсан дэд захирал • НБТ, ХЕХ, ХДХ	10.0	10.0	12.0	-	-
	Сургалт явуулах анги танхимын зохион байгуулалт, сургалтын орчныг бий болгох арга зүйг эзэмшүүлэх	Зөвлөгөө, арга зүй, сургалт	Суралцахуйн орчны шинэчлэл хийгдсэн анги танхимийн тоо	• Асуудал хариуцсан дэд захирал • НБТ, ХЕХ, ХДХ	10.0	10.0	12.0	-	-

2.3 Сургалтын хөтөлбөр боловсруулах, үнэлэх, хөгжүүлэх арга барилыг тасралтгүй дээшлүүлнэ.	Сургалтын хөтөлбөр боловсруулах арга барилыг тасралтгүй дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлж ажиллах	Зөвлөгөө, арга зүй, сургалт	Салбар дундын болон хамтарсан хөтөлбөрийн тоо, хичээлийн тоо	<ul style="list-style-type: none"> Асуудал хариуцсан дэд захирал НБТ, ХЕХ, ХДХ 	6.0	10.0	12.0	15.0	18.0
	Сургалтын хөтөлбөрийг үнэлэх, хөгжүүлэх арга барилыг тасралтгүй хөгжүүлэх	Зөвлөгөө, арга зүй, сургалт	магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн тоо, хичээлийн тоо	<ul style="list-style-type: none"> Асуудал хариуцсан дэд захирал НБТ, ХЕХ, ХДХ 	6.0	10.0	12.0	15.0	18.0
Дүн, сая.төг					44.0	60.0	72.0	60.0	72.0
III. Профессор багшийн сургалт, судалгаа, инновацийн ур чадварыг дэмжинэ.									
3.1.Багшийн судалгааны ур чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	Профессор багшийн гадаад дотоод харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжийг олон улсын түвшинд хүргэхэд дэмжлэг үзүүлэх	Зөвлөгөө, арга зүй, сургалт	Мэргэжлийн түвшинд хянагддаг сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийн тоо, чанар, хэрэгжүүлсэн төсөл, гэрээт ажлын тоо, чанар, үр өгөөж	<ul style="list-style-type: none"> Асуудал хариуцсан дэд захирал НБТ ХЕХ, ХДХ 	10.0	12.0	15.0	18.0	10.0
	Эрдэм шинжилгээний бүтээлийн олон улсын эшлэлийн системд багтдаг, өндөр импакт фактор бүхий мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл нийтлүүлсэн гадаад дотоодын багш нарын туршлагаас суралцахад нь дэмжлэг үзүүлэх	Зөвлөгөө, арга зүй, сургалт	ЭШ-ний бүтээлийн олон улсын ишлэлийн системд багтсан, өндөр импакт фактор бүхий мэргэжлийн сэтгүүлд нийтлүүлсэн өгүүлэл, багшийн тоо	<ul style="list-style-type: none"> Асуудал хариуцсан дэд захирал НБТ ХЕХ, ХДХ 	6.0	10.0	12.0	15.0	18.0
3.2. Багш судалгааны ажлын үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, бойжуулах бизнес сэтгэлгээг нь хөгжүүлж, баялаг бүтээх манлайлыг дэмжин ажиллана.	Багшийн судалгааны ажилд зөвлөх, нэвтрүүлэх үйлчилгээг бүх чиглэлээр хөгжүүлэх	Зөвлөгөө, арга зүй, сургалт	Багш нарын үйлдвэрлэлд нэвтрүүлсэн бүтээлийн тоо, Нээлттэй судалгааны лаборатори, Судалгааны хөрөнгө оруулалт, Хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн тоо	<ul style="list-style-type: none"> Асуудал хариуцсан дэд захирал НБТ ХЕХ, ХДХ 	6.0	10.0	12.0	15.0	18.0
	Багшийн манлайлах ур чадварыг тасралтгүй хөгжүүлэхэд дэмлэг үзүүлнэ.	Зөвлөгөө, арга зүй, сургалт	Оюутны ЭШ-ний хурал, мэргэжлийн наадам, тэмцээн уралдаанд оролцуулсан оюутны тоо	<ul style="list-style-type: none"> Асуудал хариуцсан дэд захирал НБТ ХЕХ, ХДХ 	6.0	10.0	12.0	15.0	18.0
3.3 Салбар мэргэжлийн тэнхимтэй хамтран төгсөгч, ажил олгогч нартай хамтран насан туршийн боловсрол, ур чадвар олгох сургалтуудыг зохион байгуулна.	Салбар мэргэжлийн тэнхимтэй хамтран төгсөгч, ажил олгогч нарт зориулсан насан туршийн боловсрол, ур чадвар олгох сургалтуудыг зохион байгуулна.	Зөвлөгөө, арга зүй, сургалт	Суралцагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ,	<ul style="list-style-type: none"> Асуудал хариуцсан дэд захирал НБТ ХЕХ, ХДХ 	6.0	10.0	12.0	15.0	18.0
3.4 Сургалт-судалгаа-үйлдвэрлэл буюу үйлдвэр ажил олгогчийн хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр сургалтын хөтөлбөрийн багуудтай хамтран ажиллана.	Сургалт-судалгаа-үйлдвэрлэл буюу аж үйлдвэр ажил олгогчийн хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр сургалтын хөтөлбөрийн багуудтай хамтран ажиллана.	Зөвлөгөө, арга зүй, сургалт	Удирдаж хамгаалуулсан төгсөгчийн тоо /бакалавр, магистр, доктор/ Сургалтын хөтөлбөрд оролцуулсан суралцагчийн тоо,	<ul style="list-style-type: none"> Асуудал хариуцсан дэд захирал НБТ ХЕХ, ХДХ 	10.0	12.0	15.0	18.0	18.0

хамтран ажиллана.			Хамтран ажилласан үйлдвэр, бизнесийн байгууллагын тоо, ажлын үр дүн						
	Дүн, сая.төг				44.0	64.0	78.0	96.0	100.0
IV. Профессор багшийн нийгмийн үйлчилгээ, хамтын ажиллагааны үр чадварыг бэхжүүлнэ.									
4.1.Бүтээлч сэтгэлгээ, зөөлөн ур чадвар, ёс зүйтэй, хөрвөх чадвартай багшийн хөгжлийг дэмжинэ.	ШУТИС-ийн багшид тавигдах шаардлагад нийцсэн багшийн бүтээлч сэтгэлгээ, зөөлөн ур чадварыг хөгжүүлэх	Зөвлөгөө, арга зүй, сургалт		<ul style="list-style-type: none"> Асуудал хариуцсан дэд захирал НБТ, ХЕХ, ХДХ 	6.0	10.0	12.0	15.0	18.0
	Багшийн болон суралцагчийн үнэт зүйлс, ёс зүйн хэмжээг тодорхойлох арга зүйг боловсронгуй болгох	Зөвлөгөө, арга зүй, сургалт		<ul style="list-style-type: none"> Асуудал хариуцсан дэд захирал НБТ, ХЕХ, ХДХ 	6.0	10.0	12.0	15.0	18.0
4.2. Нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, хүмүүнлэгийн болон сайн дурын үйл ажиллагаа явуулах сэтгэлгээг дэмжинэ.	ШУТИС-ийн багш, судлаачдын онолын мэдлэг, түүнийг хэрэглэх чадамжийг нь нийгэм, эдийн засаг, шинжлэх ухааны эрэлт хэрэгцээтэй уялдуулах	Зөвлөгөө, арга зүй, сургалт		<ul style="list-style-type: none"> Асуудал хариуцсан дэд захирал НБТ, ХЕХ, ХДХ 	6.0	10.0	12.0	15.0	18.0
	Нийгэм хүмүүнлэгийн сайн үйлсийг удирдах манлайлах ур чадварыг хөгжүүлэх	Зөвлөгөө, арга зүй, сургалт		<ul style="list-style-type: none"> Асуудал хариуцсан дэд захирал НБТ, ХЕХ, ХДХ 	6.0	10.0	12.0	15.0	18.0
4.3.Сургалт, судалгааны чиглэлээр салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах ур чадварыг дээшлүүлнэ.	Салбар дундын шинжлэх ухааныг хөгжүүлэх оновчтой механизмыг бүрдүүлж ажиллахад нь дэмжлэг үзүүлэх	Зөвлөгөө, арга зүй, сургалт		<ul style="list-style-type: none"> Асуудал хариуцсан дэд захирал НБТ, ХЕХ, ХДХ 	6.0	10.0	12.0	15.0	18.0
	Хамтын судалгаа, багаар ажиллах ур чадварыг нэмэгдүүлэх	Зөвлөгөө, арга зүй, сургалт		<ul style="list-style-type: none"> Асуудал хариуцсан дэд захирал НБТ, ХЕХ, ХДХ 	6.0	10.0	12.0	15.0	18.0
	Дүн, сая.төг				36.0	60.0	72.0	90.0	106.0
	Нийт дүн, сая төг				162.0	244.0	298.0	331.0	372.0

2.4 Хөтөлбөрийн удирдлага, санхүүжилт

- Багшийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат, үр дүнгийн шалгуур үзүүлэлттэй уялдуулан бүрэлдэхүүн сургуулийн захирал жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө багшийн хөгжлийн чиглэлээр зорилтот ажлуудыг тусган хэрэгжүүлнэ.
- Нээлттэй боловсролын төв нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд ШУТИС-ийн ректороор жил бүрийн ажлын төлөвлөгөөг батлуулан мөрдөж ажиллана.
- Нээлттэй боловсролын төв нь захиргааны нэгж, бүрэлдэхүүн сургууль, салбар, тэнхимтэй хамтран багшийн ур чадварыг хөгжүүлэх ажлыг зохион байгуулна.
- Багшийн ур чадварыг хөгжүүлэх бүрэлдэхүүн сургууль бүр дээрх нэгжийн ажлын төлөвлөгөөг ШУТИС-ийн стратеги төлөвлөгөө, Багшийн ур чадварыг хөгжүүлэх хөтөлбөр, Багш нарын хувийн хөгжлийн төлөвлөгөөнд үндэслэн, салбар, тэнхим, бүрэлдэхүүн сургууль бүр боловсруулан баталгаажуулж, хувийг жил бүрийн 6-р сарын 15-ны дотор НБТ-д ирүүлэн дараа жилийн төлөвлөгөөнд тусгана.
- Батлагдсан төлөвлөгөөний дагуу багшийг ажлын байран дээр болон үйлдвэрийн орчинд хөгжүүлэх үйл ажиллагааг салбар, тэнхим, бүрэлдэхүүн сургууль, НБТ дангаараа болон хамтран зохион байгуулж, хяналт тавин ажиллана.
- Багшийн ур чадварыг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай үйл ажиллагааны нийт санхүүжилтийг хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй хамт батална.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ. Үүнд:
 - ШУТИС-ийн төвлөрсөн болон бүрэлдэхүүн сургуулиудын төсөв
 - Эрдэм шинжилгээ, судалгааны санхүүжилт
 - Улсын төвлөрсөн төсөв
 - Гадаад, дотоодын төсөл, хөтөлбөр
 - Хандив тусламж
 - Бусад эх үүсвэр
- Хөтөлбөрийн санхүүжилтийг холбогдох нэгжүүдийн саналыг үндэслэн төлөвлөлтийн газар төлөвлөж, ШУТИС-ийн Удирдах зөвлөл батална.
- Багш, ажилтныг дэмжих үйл ажиллагааны батлагдсан төсвийг зардлын ангиллын дагуу хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зарцуулна.

ГУРАВ. БАГШИЙН УР ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ, ДЭМЖИХ

3.1 Профессор багшид тавигдах нийтлэг шаардлага

А. ШУТИС-ийн профессор багшийн мэдлэг:

- Судлагдахуун, салбар шинжлэх ухааны болон мэргэжлийн мэдлэг
- Боловсролын онол арга зүй, боловсрол судлал, боловсролын сэтгэлзүйн мэдлэг
- Аливааг шинжлэх ухааны үндэслэлтэй судлан, шинжлэх, судалгааны ажлын арга зүйн мэдлэг
- Нийгэм, хувь хүний хариуцлагын талаар мэдлэг
- Боловсролын салбарын болон түүнтэй холбогдох хууль эрх зүйн мэдлэг
- Байгаль, хүрээлэн буй орчны талаарх мэдлэг
- Нийгэм, соёлын талаарх мэдлэг (хувь хүний сэтгэл судлал ба нийгмийн сэтгэл судлал, жендерийн эрх тэгш байдал, нийгмийн эрүүл мэндийн боловсрол)
- Сургалтад шинэ, дэвшилтэт технологийг хэрэглэх мэдлэгтэй байх

- Гадаад хэлний мэдлэг

В. ШУТИС-ийн профессор багшийн хандлага төлөвшил:

- Хууль эрх зүйн хэм хэмжээг эрхэмлэх, дагаж мөрдөх
- Хувь хүний болон судлаачийн ёс зүйтэй байх
- Хувь хүний болон байгууллагын нууцыг хадгалах
- Хувь хүн болон нийгмийн ашиг сонирхолд ээлтэй хандах
- Мэргэжлийн болон судалгааны мэдлэг ур чадвараа тасралтгүй хөгжүүлж, насан туршийн суралцагч байх
- Олон улсын болон үндэсний түүх, соёл, уламжлалыг хүндлэн дээдэлж, хөгжилд хувь нэмэр оруулах эрмэлзэлтэй байх
- Мэдээлэл, харилцаа холбооны технологийн аюулгүй, хариуцлагатай, ёс зүйтэй хэрэглээг мөрдөх
- Хүнлэг энэрэнгүй, нигүүлсэнгүй, шударга, хариуцлагатай сэтгэл зүйн зөв төлөвшилтэй байх
- Үндэсний соёл уламжлал болон олон талын нээлтэй, тэгш оролцоог эрхэмлэсэн байгууллагын соёлыг бий болгох хүсэл эрмэлзэлтэй байх, уламжлалт соёлыг дагаж мөрддөг ёс зүйтэй байх

С. Профессор багшийн ур чадвар:

- Харилцааны ур чадвар
- Системтэйгээр бодох чадвар
- Багаар ажиллах чадвар
- Бусдыг ойлгох, сэтгэл хөдлөлөө удирдах чадвар
- Асуудлыг цогцоор нь шийдвэрлэх чадвар
- Удирдан чиглүүлэх чадвар
- Туршилт хийх, мэдлэг бүтээх чадвар
- Дижитал технологи ашиглах чадвар
- Дижитал ур чадвар (сошиал медиа, дата аналитик, видео)
- Гадаад хэлээр харилцах чадвар
- Байнга суралцах чадвар
- Санхүү менежментээ зөв удирдах чадвартай байх

Профессор багшийн албан тушаалын ангилал тус бүр дээр тавигдах нийтлэг шаардлагыг Хавсралт 1-д үзүүлэв.

3.2 Профессор багшийн чадамж, үнэлгээ

Профессор багшийн чадамж

Судалгаа, инновац, сургалтын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, мэргэжлийн болон нийгмийн хүрээнд үйлчилгээ үзүүлэх сэтгэлгээ, үйл дадал, хандлагын чадваруудын цогц.

ШУТИС-ийн профессор багш нь өндөр түвшний мэдлэг оюун, үнэт зүйл, ур чадвараа ашиглан судалгаа инновацын ажил хийх, хэрэгжүүлэх, сургалтын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, мэргэжлийн болон нийгмийн хүрээнд үйлчилгээ үзүүлэх чадамжтай байхаас гадна хувь хүний манлайллын, судалгаа инновацын, багшлахуйн, гэсэн 3 цогц чадамжийн хүрээнд тасралтгүй хөгжинө. Хөтөлбөрийн зорилтыг ханган хэрэгжүүлэх үйл ажиллагааг профессор багшийн чадамжид тулгуурлан төлөвлөж, зохион байгуулна.

3.2.1 Хувь хүний манлайллын чадамж:

Мэргэжлийн болон хувь хүний мэдлэг, чадвараа тасралтгүй үе шаттайгаар хөгжүүлэх, үйл ажиллагааг удирдах сэтгэлгээ, үйл дадал, хандлагын чадваруудын цогц. Профессор багш нь өөрийн мэргэжлийн болон хувь хүний чадвараа тасралтгүй үе шаттайгаар хөгжүүлэхэд анхаарч, үйл ажиллагааг удирдах мэдлэг, ур чадварыг байнга эзэмшиж, ёс зүйн зөв хандлагатай байна. Энэхүү чадамж нь зөөлөн ур чадвар, техникийн ур чадвар, хувь хүний манлайллын ур чадвар гэсэн 3 хэсгээс бүрдэнэ. Зөөлөн ур чадвар нь:

- Харилцааны болон зөв хандлагатай байх
- Бусдыг ойлгох, сэтгэл хөдлөлөө удирдах, тэвчээр, хатуужилтай байх
- Асуудлыг цогцоор нь шийдвэрлэх
- Ёс зүйн зөв хандлагатай байх
- Бүтээлч, шинийг эрэлхийлэгч байх чадвараас бүрдэнэ.

Техникийн ур чадвар нь:

- Багаар ажиллах
- Бичиг баримтыг боловсруулах
- Санхүү менежментээ зөв удирдах
- Мэргэжлийн мэдлэг оюунаа ашиглах
- Дижитал ур чадвар (сошиал медиа, дата аналитик, видео)-аа ашиглах чадвараас бүрдэнэ.

Хувь хүний ур чадвар нь:

- Манлайлах удирдан чиглүүлэх
- Насан туршийн суралцагч байх
- Хувь хүний болон байгууллагын нууцыг хадгалах
- Цагийн менежменттэй байх
- Үндэсний уламжлал, соёлыг дээдэлдэг байх чадвараас бүрдэнэ.

3.2.2 Судалгаа, инновацын чадамж

Мэргэжлийн стандартад нийцсэн судалгаа, инновацын ажлыг удирдан явуулах, судлаачийн ёс зүйг дээдлэх чадваруудыг эзэмшсэн байна. Судалгааны онол, арга зүйн болон судалгааны менежмент хийх чадвар орно.

Судалгааны онол, арга зүйн чадвар нь:

- Судалгааны онол, арга зүйтэй байх
- Судлаачийн ёс зүйтэй байх
- Судалгааны програм хангамж, техник технологийг эзэмшсэн байх
- Оюуны өмчийг эзэмших, ашиглах
- ШУ-ны шинэ чиглэл, ололт онолыг эрэлхийлэх, эзэмшихээс бүрдэнэ.

Судалгааны менежмент хийх чадвар нь:

- Судалгааны үр дүнгээр өгүүлэл, тайлан бичих
- Судалгааг хэвлэн нийтлэх түгээн дэлгэрүүлэх
- Судалгаа, төслийн эх үүсвэр, санхүүжилт бүрдүүлэх, гарааны компани байгуулах
- Судалгаа, төсөл, хөтөлбөрийн хүрээнд судлаачийг удирдах
- Судалгаа, төсөл, хөтөлбөрийг удирдах, хэрэгжүүлэх, оролцох чадвартай байна.

3.2.3 Багшлахуйн чадамж

Нийгэм, эдийн засаг, эрдэм шинжилгээ, судалгааны хүрээнд салбар шинжлэх ухаан, мэргэжлийн мэдлэг, ур чадвараа түгээн дэлгэрүүлэх, багшлахуй, сургалтын үйл ажиллагааг удирдан, зохион байгуулах чадамжтай байна. Багшлахуйн болон сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах чадвар орно.

Багшлахуйн чадвар нь:

- Сургалтын хөтөлбөр болон хичээлийн хөтөлбөр боловсруулах, хөгжүүлэх
- Багшлахуйн арга зүй, технологийг эзэмших, хэрэгжүүлэх
- Багш хамт олон болон суралцагчдад зөвлөх
- Нийгмийн болон мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх
- Цахим хэрэглэгдэхүүн болон шинэ дэвшилтэт техник, технологийг хэрэглэх чадвараас бүрдэнэ.

Сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах чадвар нь:

- Суралцахуйн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах
- Суралцагч төвтэй сургалтын орчинг бүрдүүлэх
- Үнэлгээ, дүгнэлт хийх
- Сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэх, хэрэглэх
- Сургалт, үйлдвэрлэл, нийгмийн болон мэргэжлийн үйлчилгээг хослуулан гүйцэтгэх чадвар орно.

3.2.4 Багшийн чадамжийн үнэлгээ

Хүний нөөцийг чадавхжуулах, багшийн үр дүнтэй бүтээлч үйл ажиллагааг дэмжих, харьцуулагдан үр өгөөжөө тооцож болдог нэгдсэн тогтолцоотой болох зорилгоор багшийн чадамжийн үнэлгээг хийнэ. Багшийн чадамжийг багшлахуй, судалгаа инновацын, хувь хүний манлайллын чадамж гэсэн 3 чадамжийн хүрээнд нэгтгэн дүгнэх ба багш хамт олон, багш нарыг өөрсдийнх нь хүсэлт, үнэлгээний тайлангийн дагуу үнэлж, чадамжийн гэрчилгээг олгоно. Үнэлгээг салбар тэнхим, бүрэлдэхүүн сургуулийн комисс хийж, үр дүнгээр багшийг дэмжих урамшуулах эсвэл чадамжийг хөгжүүлэх чиглэлээр шаталсан сургалтуудад хамруулах ажлыг зохион байгуулна.

Үнэлгээг дараах дарааллын дагууд явуулна. Үүнд:

1. Багшийн хүсэлт, өөрийн үнэлгээний тайлангаар үнэлгээг эхлүүлнэ.
2. Тухайн багш нь нотлох баримтуудаа цуглуулж, түвшин тус бүрд харгалзах таван онооны аль нэг түвшнээр үнэлүүлнэ.
3. Түвшин бүрийн шалгуур нь тодорхойлолт болон үндэслэлд тулгуурлана.
4. Түвшин тус бүрийн нийцлийг илтгэх нотлох баримтуудын мөн чанарыг онцолж үзнэ.
5. Рубрикийн үнэлгээний аргачлалыг ашиглах ба энэ нь шаталсан бүтэцтэй, дээд түвшин нь доод түвшнээ агуулсан байдаг. Жишээ нь: 5-р түвшин нь тасралтгүй сайжруулах үйл явцыг тусгасан байх ба 4-р түвшинд хүрсэн байхыг шаардана.

А. Багшийн судалгаа, инновацын чадамж

Хувь хүний ур чадвар болон бүтээгдэхүүн, үйл ажиллагаа, систем бий болгох ур чадваруудыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх ур чадварууд нь сургалт судалгааны орчин нөхцөлд илүү сайн хөгждөг. Багшийн судалгаа инновацын хамрах хүрээ нь сургалт судалгааны зорилго, эх үүсвэр, салбар шинжлэх ухааны чиглэлээс хамаарч ялгаатай байх тул чадамжийн үнэлгээнд үйлдвэрийн газар түр хугацаанд ажиллах, судалгаа шинжилгээ болон сургалтын инновацын төсөл дээр үйлдвэрийн газрын мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах зэргийг оруулах ба шинээр ажилд авах болон тушаал дэвшүүлэхэд судлаачийн болон мэргэжлийн дадлага, туршлагыг нэг шалгуур үзүүлэлт болгоно.

N	Чадварууд	Албан тушаал					Харгалзах оноо, шалгуур				
		Дад багш	Багш	Ахлах багш	Дэд проф	Проф	5	4	3	2	1
							Шаардагдах ур чадварыг мэргэжлийн түвшинд эзэмшсэн High professional	Шаардагдах ур чадварыг сайн эзэмшсэн ахисан түвшин Advanced	Шаардагдах ур чадварыг хангалттай Эзэмшсэн Moderatory-standard	Хэрэгжүүлэх, гүйцэтгэж буй ажлын хувьд илрэх илрэл хангалттай бус /Execution/	Мэдлэг, туршлага хангалтгүй /Basic/
1	Судалгааны онол, арга зүйтэй байх		3	3	4	5					
2	Судлаачийн ёс зүйтэй байх										
3	Судалгааны программ хангамж, техник технологийг эзэмшсэн байх										
4	Оюуны өмчийг эзэмших, ашиглах										
5	ШУ-ны шинэ чиглэл, ололт онолыг эрэлхийлэх, эзэмших										

Хүснэгт 6. Багшийн судалгаа инновацын чадамжийг үнэлэх шалгуур

Түвшинг үнэлгээ	Шалгуур үзүүлэлт	Баримт, нотолгооны жишээ
5	Мэргэжлийн салбарын хүрээнд тулгамдсан асуудлыг тодорхойлон гарц шийдлийг таамаглах, тодорхойлох, шинэ санал санаачилга, концепц гаргах, тухайн дэвшүүлсэн санал санаачилга, гарц шийдлийн талаар шинжлэх ухааны үндэслэлтэй судалгааны төсөл төлөвлөх, төслийн санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлох, төслийн багийг бүрдүүлэх, судалгааны багийг нэгдсэн удирдлагаар хангах, судалгааны үр дүнг олон улсын түвшинд түгээн дэлгэрүүлэх, шинэ бүтээгдэхүүн, үр өгөөжтэй үйлчилгээ болгон хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, манлайлах, судалгааны хүрээнд гадаад дотоод хамтын ажиллагааг өргөжүүлдэг.	Бүтээлч үйл ажиллагаа нь сургалт, судалгааны орчныг шинэчлэн сайжруулж буй нь нотлогдон үр дүн нь илэрхий бий болсон, Шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулсан төслүүд нь хэрэгжсэн, сургалт судалгааны үр өгөөж нь хэрэгжиж буй нь нотлогдсон, үйлдвэрлэл ажил олгогч, хамтын ажиллагаа бүхий байгууллагатай хамтран бодит үйл ажиллагааг дэмжих курсийн болон дипломын төслүүдийг зохион байгуулан удирддаг, төслийн үр дүнгээр сургалт судалгааны лаборатори нь шинэчлэгдэн өргөжсөн, салбар чиглэлийн хүрээнд тулгамдсан асуудлын гарц шийдлийг тодорхойлоход санал, үзэл баримтлал дэвшүүлсэн нь шийдвэрт тусгагдсан.
4	Төсөл хөтөлбөрийн санал боловсруулах, төслийн бичиг баримт бүрдүүлэх, хэрэгжүүлж буй эрдэм шинжилгээ, судалгааны төслийг гүйцэтгэлийг хангуулах, төслийн баг судлаачдад дэмжлэг үзүүлэх, төсөл хөтөлбөрийн санхүүжилт босгох гадаад дотоод харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр бүтээлчээр ажилладаг.	Төслүүд нь хэрэгждэг, сургалт судалгааны үр өгөөж нь хэрэгжиж буйг нотолсон хамтарсан төслүүдийг удирддаг, төслийн үр дүнгээр сургалт судалгааны лаборатори нь шинэчлэгдэн өргөжсөн, суралцагчийн мэдлэг, чадвар, хандлагад эсрэгээр нөлөөлсөн, хөтөлбөрөөр элсэгчийн тоо нэмэгдсэн, төгсөгчдийн чадамж өссөнийг ажил олгогч бодитоор үнэлэн мэргэжлийн ажлын байраар төгсөгчийг хангасан, үйлдвэрлэл сургалтын үйл ажиллагааг бодит төслөөр уялдуулан сургалт судалгааг өөрөө явуулдаг, суралцагчдад энэхүү аргаа эзэмшүүлдэг, нийгэмд болон дотоод гадаад хөтөлбөр, үйл ажиллагаа нь оюутан төгсөгч, байгууллагаар дамжин танигдсан, магадлан итгэмжлэгдсэн
3	Үндэсний болон олон улсын хэмжээнд судалгаа хийх, судалгааны өгөгдлийг нэгтгэх, боловсруулах, дүн шинжилгээ хийх, нэгтгэн дүгнэх, тайлагнах, судлаач оюутнуудыг бэлтгэх, зөвлөх, сургах, эрдэм шинжилгээний бүтээл бичих, хэвлүүлэх, гадаад болон дотоодын эрдэм шинжилгээний хуралд оролцох, судалгааны ажлын үр дүнг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр үр бүтээлтэй ажилладаг.	Үндэсний болон олон улсын хэмжээний судалгааны ажлын тайланг боловсруулдаг. Судлаачдад судалгааны ажлын арга зүйг заан зөвлөдөг, дүн шинжилгээ хийх, нэгтгэн дүгнэх, тайлагнах, судлаачдыг бэлтгэдэг, эрдэм шинжилгээний бүтээл бичих, хэвлүүлэх, гадаад болон дотоодын эрдэм шинжилгээний хуралд судалгааны ажлын үр дүнг хэлэлцүүлдэг, түгээн дэлгэрүүлдэг.
2	Судалгааны баг, судлаач, оюутныг удирдан чиглүүлэх, судалгааны ажил бие даан гүйцэтгэх, судалгааны арга зүйг түгээн дэлгэрүүлэх, төслийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг хариуцан ажиллах чиглэлээр бүтээлчээр ажилладаг.	Томоохон үйлдвэрлэл, компанид багш нар удаан хугацаанд (ядаж долоо хоног) дадлагажих, мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрт хамрагдсан. Багш нар хувь хүн ба хүмүүс хоорондын харилцааны чадвар, бүтээгдэхүүн, үйл ажиллагаа, систем бий болгох чадвар болон бусад сэдвүүдээр хэлэлцэн чанарыг сайжруулах арга хэрэгсэлд суралцан, эдгээр чадвар нь сургалтын төслийн загвар, үйлдвэртэй хамтарсан судалгааны төсөл болон үйлдвэр дээр хийсэн дипломын төслүүдийг удирдахад хөгжсөн.
1	Сургалтад инновац хэрэглэх, салбар шинжлэх ухаан, мэргэжлийн чиглэлээр судалгаа хийх, шинжлэх ухааны бүтээлийг хайх, унших, боловсруулах, нэгтгэн дүгнэх, туршилт судалгаа төлөвлөх, судалгааны арга зүйг эзэмших туршилт хийх, судалгааны өгөгдлийг цуглуулах, мэдээллийг боловсруулах, тайлбарлах, судалгааны үр дүнг түгээн дэлгэрүүлэх ажилд туслах, судалгаа эрдэм шинжилгээний өгүүлэл бичих, хэвлүүлэхэд суралцан ажилладаг.	Сургалтад инновац нэвтрүүлж хэрэглэдэг, салбар шинжлэх ухаан, мэргэжлийн чиглэлээр судалгаа хийж, тайлан, бүтээл гаргасан, Судалгаа эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж хэвлүүлсэн.

Б. Багшийн багшлахуйн чадамжийн үнэлгээ

Багшийн мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх, олон талт суралцахуйн арга туршлага, идэвхтэй суралцахуй болон оюутны суралцах үйл явцыг үнэлэх чиглэлээр багшлах бүрэлдэхүүний чадамжийг

дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой. Багш нь дэвшилтэт шинэ арга зүй, зарчмуудыг ашиглан сургалт явуулахаар төлөвлөдөг, хэрэгжүүлдэг түүнийгээ үнэлдэг, үнэлүүлдэг байх нь чадамжаа сайжруулах, хөгжих суурь болно.

Хүснэгт 7. Багшийн багшлахуйн чадамжийг үнэлэх шалгуур

Түвшинт үнэлгээ	Шалгуур үзүүлэлт	Баримт, нотолгооны жишээ
5	Багшлахуйн, суралцахуйн, арга зүй, технологи, үнэлгээний аргачлалыг байнга хэрэглэж, шаардлагатай үед сайжруулах үйл ажиллагааг явуулдаг.	Багш сургалтын ажилдаа тогтмол үнэлгээг хийж, хөтөлбөрийг хөгжүүлэх төлөвлөгөөний дагуу үр дүнтэй арга зүйг хэрэгжүүлэн үр дүнд хүрсэн нь оюутан, хамт олны үнэлгээгээр батлагдсан. Жил бүрийн багшийн гүйцэтгэлийн тайландаа заах, сургах болон үнэлгээг сайжруулах тодорхой төлөвлөгөөний зураглалыг хувийн хөгжлийн төлөвлөгөө, баримтдаа тусгадаг. Гадаад, дотоодод оюутнуудыг хамтарсан хөтөлбөрөөр суралцуулсан, нийгэмд болон дотоод гадаадад хөтөлбөр, үйл ажиллагаа нь оюутан төгсөгч, байгууллагаар дамжин танигдсан, хөтөлбөр нь магадлан итгэмжлэгдсэн.
4	Багш сургалтын арга зүйн хангалттай чадамжтайг харуулсан нотлох баримттай.	Нэг ба түүнээс дээш хичээлд боловсролын инновацын үйл ажиллагааг эхлүүлэн тэнхим, салбарын төлөвлөгөөнд энэхүү зорилгыг хэрэгжүүлэхээр тусган, хэрэгжүүлдэг. Сургалтын үйл ажиллагаа судалгааны ажлын уялдаа холбоог ойлгон хөтөлбөр боловсруулалтад тусгадаг, суралцагчтай ойлголцох тэдэнд чадамж эзэмшүүлэх арга зүйд суралцсан.
3	Багшийн багшлахуйн, суралцахуйн чадамжаа хөгжүүлэх сургалтад байнга хамрагддаг.	Идэвхтэй, туршлагад суурилсан сургалт мөн хувь хүний чадвар, хандлага, багийн ажиллагаа, харилцааг үнэлэх аргачлалын талаар сургалтанд хамрагдан, түүнийг үйл ажиллагаандаа хэрэглэдэг.
2	Багшийн багшлахуйн, суралцахуйн, үнэлгээний арга зүйн чадамжийг хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагааны системчилсэн төлөвлөгөөтэй.	Хичээлийг зохион байгуулах, ур чадварыг үнэлэх, дасгалжуулах болон баг доторх оюутнуудын хоорондох үл ойлголцлыг зохицуулах зэрэг үйл ажиллагааг үр дүнтэй удирдан чиглүүлдэг. Багш нарт зориулсан ур чадварын, харилцааны, төслийн менежмент болон оюутнуудтай харилцах талаар сургалтуудад хамрагдаж, үйл ажиллагаандаа нэвтрүүлж хэрэгжүүлсэн.
1	Багшлахуйн чадамжийн жишиг тогтоох судалгаа, хэрэгцээний дүн шинжилгээ хийсэн.	Тухайн жилд ямар сургалтад хамрагдах шаардлагатайг ойлгон, судалгаанд хамрагдан, төлөвлөгөө гаргаж, үйлдвэрийн орчинд болон ажлын байран дээр дадлагажих, чадавхжих төлөвлөгөөтэйгээр ажиллана.

3.3 Багшийн цогц чадамжийг дэмжих сургалтын төлөвлөгөө

Багшийн хөгжлийг дэмжих сургалт нь анхан, дунд, ахисан шатны гэсэн 3 түвшинтэй, түвшин бүрийн сургалтын үр дүн нь багшийн чадамжийг хөгжүүлэхэд чиглэнэ.

3.3.1 Багшийн чадамжийг дэмжих сургалтын төлөвлөлт

Хүснэгт 8. Сургалтын төлөвлөлт

д/д	Чиглэл		Анхан шатны сургалт		Дунд шатны сургалт		Ахисан шатны сургалт	
			Хичээлийн нэр	Багц цаг	Хичээлийн нэр	Багц цаг	Хичээлийн нэр	Багц цаг
1	1. Багшлахуйн чадамжийг хөгжүүлэх	Удиртгал, онол	S.HE601 Боловсролын онол, арга зүй	1	S.HE611 Боловсролын хөтөлбөрийг боловсруулах арга зүй	1	S.HE621 ҮДСБ-ын онол, арга зүй	1
2		Боловсролын болон хичээлийн хөтөлбөр боловсруулах, хөгжүүлэх	S.HE602 Суралцахуйн дизайн	1	S.HE612 Хөтөлбөрийн дизайн боловсруулалт	1	S.HE622 Хөтөлбөр хөгжүүлэх арга зүй	2
3		Үнэлгээний дэвшилтэт арга зүйд суралцах	S.HE603 Сургалтын технологи арга зүй, анализ	1	S.HE613 Хөтөлбөрийн үнэлгээ	2	S.HE623 Сургалтын дотоод чанарын баталгаажуулалт	2
4		Сургалтын үйл ажиллагааг удирдах, дэмжих	S.HE605 Багшийн МХХИ-ийн чадамжийн тогтолцоо	1	S.HE615 Цахим сургалтын арга зүй	2	S.HE625 Дижитал шилжилт	2
5			S.HE606 Нээлттэй боловсрол	1	S.HE616 Нээлттэй нөөц эх материал	1	S.HE626 Нээлттэй шинжлэх ухаан	1
6	2. Судалгаа, инновацийн чадамжийг хөгжүүлэх	Судалгааны арга зүй	-	S.HE617 Судалгааны арга зүй	1	S.HE627 Судалгааны менежмент	2	
7		Судалгааны бичиг баримт боловсруулах арга зүй	-	S.HE618 Судалгааны бичиг баримт боловсруулах арга зүй	1	S.HE628 Судалгааны үр дүнг түгээн дэлгэрүүлэх арга зүй	1	
8	3. Хувь хүний манлайллын чадамжийг хөгжүүлэх	Багшийн хувь хүний хөгжил	S.HE604 Боловсролын сэтгэл судлал, ёс зүй	1	S.HE614 Зөөлөн ур чадварын хөгжил	1	S.HE624 Манлайлал	2
9			-	S.HE619 Бүтээлч ур чадварын хөгжил	1	S.HE629 Карьер хөгжил	2	
Нийт				6		11		15

3.4.2 Сургалтаар бий болох үр дүн ба багшийн цогц чадамжийг дэмжих хамаарал

А. Анхан шатны 6 багц цагийн сургалтаар багшлахуйн, судалгаа, инновацийн болон хувь хүний манлайллын чадамжийг танин мэдэхүй, сэтгэлгээний талбарын үйл ажиллагаанд хэрэглэх түвшний, хандлага мэдрэмжийн хувьд үнэт зүйлсийг тогтолцоогоор нь тодорхойлох түвшний, үйл дадлын хувьд үр ашигтай ажиллах түвшний мэдлэг, хандлага, чадварыг хөгжүүлнэ (Хавсралт 2).

Б. Дунд шатны 11 багц цагийн сургалтаар багшлахуйн, судалгаа, инновацийн болон хувь хүний манлайллын чадамжийг танин мэдэхүй, сэтгэлгээний талбарын үйл ажиллагаанд хэрэглэх түвшний, хандлага мэдрэмжийн хувьд удирдан зохион байгуулах түвшний, үйл дадлын хувьд шинэ зүйлийг бүтээх түвшний мэдлэг, хандлага, чадварыг нь хөгжүүлнэ (Хавсралт 3).

В. Ахисан шатны 15 багц цагийн сургалтаар багшийн багшлахуйн, судалгаа, инновацийн болон хувь хүний манлайллын чадамжийг танин мэдэхүй, сэтгэлгээний талбарын онол арга зүйн хүрээнд бүтээх түвшний, хандлага мэдрэмжийн хувьд үнэт зүйлсийн тогтолцоогоор тодорхойлох түвшний, үйл дадлын хувьд шинэ зүйлийг бүтээх түвшний мэдлэг, хандлага, чадварыг хөгжүүлнэ (Хавсралт 4).

3.4 Багшийн чадамжийн хөгжлийн хувийн төлөвлөлт

Профессор багш нь өөрийн чадамжийн түвшинг сайжруулах зорилгоор ур чадвараа хөгжүүлэх гадаад дотоодын сургалтад хамрагдаж, арга зүйн зөвлөгөө авч хамтран ажиллах хөгжлийн хувийн төлөвлөлтийг гаргана. Хувийн төлөвлөлтийг маягт (Хүснэгт 9)-ыг дагуу гарган холбогдох албанд хүргүүлэн дараагийн хичээлийн жилийн төлөвлөлтөд тусгуулна. Төлөвлөлтөд багш өөрийгөө хөгжүүлэх чадамжийн чиглэл, ур чадвар, хамрагдах үйл ажиллагаа, хугацаа, зорьж буй түвшин зэргээ тусган, зорьж буй үр дүнд хүрсэн эсэхээ үнэлж, сайжруулан ажиллана.

Хүснэгт 9. Багшийн чадамжийн хөгжлийн хувийн төлөвлөлт

д/д	Чадамжийн чиглэл	Чадвар	Хамрагдах үйл ажиллагааны нэр*	Зорилго, хүлээгдэж буй үр дүн /2-3 гол үр дүнгээ бичих/**	Хугацаа	Одоогийн түвшин	Зорьж буй түвшин	Чадамжаа шалгах талбар
1	Багшлахуйн чадамж	Багшлахуйн чадвар: <ul style="list-style-type: none"> Сургалтын хөтөлбөр болон хичээлийн хөтөлбөр боловсруулах, хөгжүүлэх Багшлахуйн арга зүй, технологийг эзэмших, хэрэгжүүлэх Багш хамт олон болон суралцагчдад зөвлөх Нийгмийн болон мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх Дижитал хэрэглэгдэхүүн болон шинэ дэвшилтэт техник, технологийг хэрэглэх Сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах чадвар: <ul style="list-style-type: none"> Суралцахуйн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах Суралцагч төвтэй сургалтын орчныг бүрдүүлэх Үнэлгээ, дүгнэлт хийх Сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэх, хэрэглэх Сургалт, үйлдвэрлэл, нийгмийн болон мэргэжлийн үйлчилгээг хослуулан гүйцэтгэх 						
2	Судалгаа, инновацийн чадамж	Судалгааны онол, арга зүйн чадвар: <ul style="list-style-type: none"> Судалгааны онол, арга зүйтэй байх Судлаачийн ёс зүйтэй байх Судалгааны программ хангамж, техник технологийг эзэмшсэн байх Оюуны өмчийг эзэмших, ашиглах ШУ-ны шинэ чиглэл, ололт онолыг эрэлхийлэх, эзэмших Судалгааны менежмент хийх чадвар: <ul style="list-style-type: none"> Судалгааны үр дүнгээр өгүүлэл, тайлан бичих Судалгааг хэвлэн нийтлэх, түгээн дэлгэрүүлэх Судалгаа, төслийн эх үүсвэр, санхүүжилт бүрдүүлэх, гарааны компани байгуулах Судалгаа, төсөл, хөтөлбөрийн хүрээнд судлаачийг удирдах Судалгаа, төсөл, хөтөлбөрийг удирдах, хэрэгжүүлэх, оролцох 						
3	Хувь хүний манлайллын чадамж	Зөөлөн ур чадвар: <ul style="list-style-type: none"> Харилцааны болон зөв хандлагатай байх 						

	<ul style="list-style-type: none"> • Бусдыг ойлгох, сэтгэл хөдлөлөө удирдах, тэвчээр, хатуужилтай байх • Асуудлыг цогцоор нь шийдвэрлэх • Ёс зүйн зөв хандлагатай байх • Бүтээлч, шинийг эрэлхийлэгч байх <p>Техникийн ур чадвар:</p> <ul style="list-style-type: none"> • Багаар ажиллах • Бичиг баримтыг боловсруулах • Санхүү, менежментээ зөв удирдах • Мэргэжлийн мэдлэг оюунаа ашиглах • Дижитал ур чадвар (сошиал медиа, дата аналитик, видео)-аа хөгжүүлэх <p>Хувь хүний ур чадвар:</p> <ul style="list-style-type: none"> • Манлайлах удирдан чиглүүлэх • Насан туршийн суралцагч байх • Хувь хүний болон байгууллагын нууцыг хадгалах • Цагийн менежменттэй байх • Үндэсний уламжлал, соёлыг дээдэлдэг байх 						
--	---	--	--	--	--	--	--

-
- *Сургалтад хамрагдах /гадаадад, дотоодод/
- *Туршлага судлах /гадаадад, дотоодод/
- *Салбар дундын хөтөлбөрийн багт ажиллах
- *Зөвлөх үйлчилгээ, зөвлөгөө авах /гадаадаас, дотоодод/
- *Бусад
- **Албан тушаалын зэрэглэл, түвшин ахих хүсэлт гаргах
- **Судалгааны грант тэтгэлэгт хамрагдах
- **Гадаадад өгүүллээ хэвлүүлэх
- **Судлаачийн грант авах

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. Бадарч Д, Очирхуяг Б. Дээд боловсролын секторын мэргэжлийн ур чадварын хэрэгцээний үнэлгээ. УБ., 2019
2. Бадарч Д, Очирхуяг Б. Дээд боловсролын салбарын хүний нөөцийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх стратеги төлөвлөгөө. УБ., 2019
3. Багшийн чадамжийн хүрээ, нийтлэг шаардлага боловсруулах, БСШУСЯ, АХБ, ДБШТ дэд ажлын хэсгийн тайлан, УБ., 2020
4. Боловсролын салбарын дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө. 2021-2030
5. Burke, W. W., & Litwin, G. H. A causal model of organizational performance and change. *Journal of management*. 1992
6. Дээд боловсролын салбарын 2018-2019 оны хичээлийн жилийн статистикийн мэдээллийн танилцуулга, УБ., 2019
7. Дээд боловсролын сургалтын байгууллагын багшид тавигдах нийтлэг шаардлагыг батлах тухай, БСШУС-ын сайдын 2020 оны 270 тоот тушаал
8. Дээд боловсролын сургалтын байгууллагын багшийн үнэлгээний тогтолцоог хөгжүүлэх нь, БСШУСЯ, АХБ, ДБШТ дэд ажлын хэсгийн тайлан, УБ., 2020
9. Дэлгэржав М. Багшийн хөгжил. Баримтын эмхтгэл. УБ., 2018
10. Лувсандорж Ц, Их Сургуулийн Багшийн Цалин, Үнэ Цэнэ. УБ., 2019
11. Лувсандорж Ц, Сан Э., Их сургуулийн багш, “Дээд боловсролын шинэчлэл төсөл”, 2018
12. МУИС-ийн багшийн хөгжлийн хөтөлбөр, 2019-2024
13. ХААИС-ийн багшийн хөгжлийн хөтөлбөр , 2018
14. Сургалтад инновац, дэвшилтэт технологи нэвтрүүлэх, БСШУСЯ, АХБ, ДБШТ дэд ажлын хэсгийн тайлан, УБ., 2020
15. ШУТИС-ийн багшийн хөгжил, цогц чадамжийн суурь судалгаа, УБ., 2020
16. Чойжамц Я. ”Их сургуулийн багш–хүний нөөцийн бодлого, хэрэгжилт, гарц, шийдэл”, УБ., 2018
17. Weisbord, M. R. Organizational diagnosis: Six places to look for trouble with or without a theory. *Group & Organization Studies*. 1976

--- оОо ---

ДАДЛАГАЖИГЧ БАГШИД ТАВИГДАХ НИЙТЛЭГ ШААРДЛАГА

D.Үйл				
D1. Сургалт	D2. Судалгаа	D3. Инноваци	D4. Нийгмийн үйлчилгээ	D5. Мэргэжлийн үйлчилгээ
D1.1. Хичээлийн хөтөлбөр, сургалтын үйл ажиллагаанд оролцох	D2.1. Салбар шинжлэх ухаан, мэргэжлийн чиглэлээр судалгаа хийх	D3.1. Сургалтанд инновац хэрэглэх	D3.1. Суралцагч болон олон нийтэд зориулсан мэргэжлийн чиглэлийн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд оролцох	D5.1.Өөрийн мэдлэг чадварыг тасралтгүй хөгжүүлэх, мэргэжлийн үйл ажиллагаа руу чиглүүлэхэд оролцох
D1.2. Хичээлийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх ажлыг хийх	D2.2. Шинжлэх ухааны бүтээлийг хайх, унших, боловсруулах, нэгтгэн дүгнэх	D3.2. Судалгааны үр дүн, өгөөжийг ашиглах		D5.2.Суралцагч болон олон нийтэд зориулсан мэргэжлийн чиглэлийн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд оролцох
D1.3. Суралцагчийг сургалтын үйл ажиллагаа болон нийгмийн хариуцлагатай байдалд чиглүүлэх	D2.3. Туршилт судалгаа төлөвлөх, судалгааны арга зүйг эзэмших	D3.3. Экологи, байгаль орчин, нийгэмд ээлтэй шинэ мэдлэг, инновацийг судлах, бүтээхэд эрмэлзэх	D3.2. Суралцагчдад чиглэсэн мэргэжлийн, нийгмийн болон олон нийтийн үйл ажиллагааг зохион байгуулах	
D1.4. Суралцагчийг үнэлэх үнэлгээний аргачлалыг төлөвлөх, дүн шинжилгээ хийхэд салбарын эрхлэгчтай хамтран ажиллах Сургалтын орчныг зөв зохистой төлөвлөх	D2.4. Туршилт хийх, судалгааны өгөгдлийг цуглуулах, мэдээллийг боловсруулах, тайлбарлах	D3.4. Салбар тэнхимээс санаачилж байгаа ажилд идэвхитэй оролцох	D3.3. Нийгэм болон олон нийтэд чиглэсэн сайн дурын үйл ажиллагаанд оролцох	
	D2.5. Судалгааны үр дүнг түгээн дэлгэрүүлэх ажилд туслах			
	D2.6. Судалгаа эрдэм шинжилгээний өгүүлэл бичих, хэвлүүлэхэд суралцах			

БАГШИД ТАВИГДАХ НИЙТЛЭГ ШААРДЛАГА

D.Үйл				
D1. Сургалт	D2. Судалгаа	D3. Инноваци	D4. Нийгмийн үйлчилгээ	D5. Мэргэжлийн үйлчилгээ
D1.1. Сургалтын болон хичээлийн хөтөлбөр боловсруулан, хэрэгжүүлэх	D2.1. Үндэсний болон олон улсын хэмжээнд судалгаа хийх	D3.1. Сургалтанд инновац хэрэглэх	D4.1.Салбар мэргэжлийн чиглэлээр иргэдийн мэдлэг, чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн боловсролын үйлчилгээг зохион байгуулах	D5.1.Өөрийн мэдлэг чадварыг тасралтгүй хөгжүүлэх, мэргэжлийн үйл ажиллагаа руу чиглүүлэх
D1.2. Сургалтын орчныг сайжруулах шинэлэг бүтээлч нөхцөлийг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулах	D2.2. Судалгааны өгөгдлийг нэгтгэх, боловсруулах, дүн шинжилгээ хийх, нэгтгэн дүгнэх, тайлагнах	D3.2. Судалгааны үр дүн, өгөөжийг хэрэглэх		D5.2.Мэргэжлийн чиглэлээр сургалт зохион байгуулах
D1.3. Суралцагчийн ухамсартай сурах үйл явцыг чиглүүлэн удирдаж, зохион байгуулах	D2.3. Судлаач оюутнуудыг бэлтгэх, зөвлөх, сургах	D3.3. Экологи, байгаль орчин, нийгэмд ээлтэй шинэ мэдлэгийг эзэмших	D4.2.Мэргэжлийн холбоод, салбарт байгаа мэргэжилтэнүүдийн хоорондын хамтын үйл ажиллагаанд идэвхи санаачлагатай оролцох	D5.3.Суралцагчид болон олон нийтэд зориулсан мэргэжлийн онол-арга зүйн зөвлөмж мэдээлэл бэлтгэх, ажлын арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх
D1.4. Хичээлийн болон сургалтын хөтөлбөрийн хүрээнд суралцагчийг үнэлэх аргачлалыг хэрэгжүүлэх, дүгнэлт гаргах	D2.4. Эрдэм шинжилгээний бүтээл ном, сурах бичиг, лабораторийн ажлын заавар, гарын авлага бичих, хэвлүүлэх	D3.4. Инновацийг ойлгох, таньж мэдэх, хийхээр эрмэлзэх, хийх	D4.3.Нийгмийг соён гэгээрүүлэх, нийгмийн сайн сайхны төлөө сайн дурын үйл ажиллагаанд оролцох	D5.4.Судалгааны ажлын үр дүн болон шинжлэх ухааны мэдлэгийг мэргэжлийн салбар, холбоод, төгсөгчид, ажил олгогчдын захиалгаар түгээн дэлгэрүүлэх үйлд санаачлагатай оролцох
D1.5. Сургалтанд шинэ дэвшилтэт технологи, арга зүй, аргачлалыг турших, нэвтрүүлэх	D2.5. Гадаад болон дотоодын эрдэм шинжилгээний хуралд оролцох, судалгааны ажлын үр дүнг түгээн дэлгэрүүлэх	D3.5. Салбар тэнхимээс санаачилж байгаа ажилд идэвхитэй оролцох	D4.4.Тогтвортой хөгжлийг таниулах, хэрэгжилтэнд хувь нэмэр оруулах, бодлогын бичиг	

D1.6. Өөрийн мэдлэг чадварыг тасралтгүй хөгжүүлэх, мэргэжлийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэх			баримт боловсруулахад санал дэвшүүлэх	D5.5.Үйлдвэрлэл, ажлын байран дээр тулгарч буй асуудлыг мэргэжлийн зүгээс шийдвэрлэх үйл ажиллагаанд оролцох
---	--	--	---------------------------------------	--

АХЛАХ БАГШИД ТАВИГДАХ НИЙТЛЭГ ШААРДЛАГА

D.Үйл				
D1. Сургалт	D2. Судалгаа	D3. Инноваци	D4. Нийгмийн үйлчилгээ	D5. Мэргэжлийн үйлчилгээ
D1.1. Сургалтын болон хичээлийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, хөтөлбөрийг тасралтгүй сайжруулах	D2.1. Судалгааны баг, судлаач, оюутныг удирдан чиглүүлэх	D3.1. Сургалтанд инновацийг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх	D4.1. Иргэдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалтыг зохион байгуулах	D5.1.Иргэдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн мэргэжлийн үйлчилгээ, сургалтыг зохион байгуулах
D1.2. Сургалтын орчныг сайжруулах арга замыг хайх, төлөвлөх	D2.2. Судалгааны ажил бие даан гүйцэтгэх	D3.2. Экологи, байгаль орчин, нийгэмд ээлтэй шинэ мэдлэг, инновацийг бүтээх	D4.2. Сургалтын болон салбар, мэргэжлийн хүрээний дүрэм, журам, санал, зөвлөмж, норм норматив, стандарт, арга зүй, аргачлал боловсруулах ажилд идэвхитэй оролцох, боловсруулах, түгээх ажилд санаачлагаараа оролцох	D5.2.Сургалтын болон салбар, мэргэжлийн хүрээний дүрэм, журам, санал, зөвлөмж, норм норматив, стандарт, арга зүй, аргачлал боловсруулах ажилд идэвхитэй оролцох, боловсруулах, түгээх
D1.3. Суралцагчийн сурах үйл явцад дүн шинжилгээ хийх, үр дүнгээр нь санал дүгнэлт гаргах	D2.3. Судалгааны арга зүйг түгээн дэлгэрүүлэх	D3.3. Инновацлаг санал санаачлага гаргах	D4.3. Тогтвортой хөгжлийг таниулах, хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах	D5.3.Мэргэжлийн холбоод, салбар мэргэжилтэнүүдийн хоорондын хамтын ажиллагаанд идэвхитэй оролцох
D1.4. Сургалтанд шинэ дэвшилтэт технологи, арга зүйн шилдэг туршлагыг санаачлах, хэрэгжүүлэх	D2.4. Төслийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг хариуцан ажиллах	D3.4. Төсөл хөтөлбөрийн санхүүжилтийг бий болгох, бүрдүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэхэд хамтарч ажиллах	D4.4. Нийгмийг соён гэгээрүүлэх, нийгмийн сайн сайхны төлөө сайн дурын үйл ажиллагаанд оролцох	D5.4.Үйлдвэрлэл, ажлын байран дээр тулгарч буй асуудлыг мэргэжлийн зүгээс шийдвэрлэх үйл ажиллагаанд оролцох
D1.5. Суралцагчийг үнэлэх үнэлгээний шинэ дэвшилтэт аргачлалыг сургалтанд хэрэгжүүлэн, гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх	D2.5. Судлаач, дадлагажигч багш болон багшийг дэмжин чиглүүлж ажиллах			
D1.6. Дадлагажигчийн зөвлөхөөр ажиллах	D2.6. Олон улсын болон үндэсний түвшинд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн санал боловсруулах, бичиг баримт бүрдүүлэх			
D1.7. Сургалтын болон мэргэжлийн ажлын баг удирдан ажиллах	D2.7. Эрдэм шинжилгээний бүтээл ном, сурах бичиг, лабораторийн ажлын заавар, гарын авлага бичих, хэвлүүлэх			
	D2.8. Сургалт, үйлдвэрлэлийн холбоог бэхжүүлэх, судалгааны ажлын ур дүнгээр эрдэм шинжилгээний хурал, үзэсгэлэн зохион байгуулахад оролцох			

ДЭД ПРОФЕССОРТ ТАВИГДАХ НИЙТЛЭГ ШААРДЛАГА

D.Үйл				
D1. Сургалт	D2. Судалгаа	D3. Инноваци	D4. Нийгмийн үйлчилгээ	D5. Мэргэжлийн үйлчилгээ
<p>D1.1. Сургалтын болон хичээлийн хөтөлбөр боловсруулах ажлыг удирдан чиглүүлэх, манлайлах</p> <p>D1.2. Сургалт, судалгааны орчныг сайжруулах, шинээр байгуулах чиглэлээр манлайлан ажиллах</p> <p>D1.3. Багшлах бүрэлдэхүүний чадварыг сайжруулах, хөгжүүлэхэд манлайлан ажиллах</p> <p>D1.4. Салбар дундын, хамтарсан хөтөлбөр боловсруулах чиглэлээр тэнхим гадаад, дотоодын их сургуультай хамтран түүчээлэн ажиллах</p> <p>D1.5. Багшлах, суралцахуйн заах арга зүйн мэдлэг, ур чадвараа түгээн дэлгэрүүлэх туршлагаа хуваалцахад манлайлах</p> <p>D1.6. Хөтөлбөрийг бүтнээр нь үнэлэх арга зүйг хэрэгжүүлэн чанарын баталгаажуулалтыг нэвтрүүлэн, үр дүнгийн гүйцэтгэлд дүнд шинжилгээ хийх, хөтөлбөрийн сайжруулалтанд тусгах, манлайлах</p>	<p>D2.1. Төсөл хөтөлбөрийн санал боловсруулах, төслийн бичиг баримт бүрдүүлэх ажлыг удирдан манлайлах</p> <p>D2.2. Хэрэгжүүлж буй эрдэм шинжилгээ судалгааны төслийг гүйцэтгэх, удирдах, санал, үндэслэлээ гаргах</p> <p>D2.3. Төслийн баг болон судлаачдад дэмжлэг үзүүлэх, манлайлан ажиллах</p> <p>D2.4. Бодлогын бичиг баримт боловсруулах, санал дэвшүүлэх</p> <p>D2.5. Эрдэм шинжилгээний бүтээл, ном, сурах бичиг, лабораторийн ажлын заавар, гарын авлага бичих, хэвлүүлэх, үйл ажиллагааг удирдан манлайлах</p>	<p>D3.1. Төсөл хөтөлбөрийн санхүүжилт босгох гадаад дотоод харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлэх</p> <p>D3.2. Судалгааны бүтээлийг хянан магадлах үйл ажиллагаанд оролцож, судалгааны чанарыг өндөрт хадгалахад хувь нэмэрээ оруулах</p> <p>D3.3. Мэдлэг сорьсон өөрчлөлтийг мэдэрч үйл ажиллагаанд тусгах, тэргүүлэх</p>	<p>D4.1. Боловсрол, ажил мэргэжлийн салбарын хүрээнд мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулах ажиллагаанд оролцох</p> <p>D4.2. Салбарын хөтөлбөрийн чанарыг баталгаажуулах, магадлан итгэмжлэх үйл ажиллагааг манлайлан, удирдах</p> <p>D4.3. Их сургууль, үйлдвэр, аж ахуйн газрын хамтын ажиллагааг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах, манлайлах</p>	<p>D5.1. Залуу багш нар, судлаачдыг дэмжин ажиллах, тэднийг чиглүүлэх</p> <p>D5.2. Боловсрол, ажил мэргэжлийн салбарын хүрээнд мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх</p> <p>D5.3. Үндэсний болон салбар, мэргэжлийн хүрээний дүрэм, журам, санал, зөвлөмж, норм, стандарт, арга зүй, аргачлал, тайлан боловсруулах, түгээх, нийтийн хүртээл болгох ажлыг манлайлах</p> <p>D5.4. Сургалтын үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр ажил олгогч, салбар мэргэжлийн түншлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх</p> <p>D5.5. Мэргэжлийн холбоод салбарын хооронд хамтын ажиллагаанд идэвхитэй манлайлан оролцох</p> <p>D5.6. Үйлдвэрлэл, ажлын байран дээр тулгарч буй асуудлыг мэргэжлийн зүгээс шийдвэрлэх үйл ажиллагааг удирдах, зохион байгуулах, манлайлах</p>

ПРОФЕССОРТ ТАВИГДАХ НИЙТЛЭГ ШААРДЛАГА

D.Үйл				
D1. Сургалт	D2. Судалгаа	D3. Инноваци	D4. Нийгмийн үйлчилгээ	D5. Мэргэжлийн үйлчилгээ
<p>D1.1.Тогтвортой хамтын ажиллагаа, стратегийн түншлэлээр дамжуулан сургалтын хөтөлбөрийг сайжруулж, салбарын хөгжлийн ирээдүйг тодорхойлох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх</p> <p>D1.2.Сургалтанд чанарын удирдлагыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг манлайлах</p> <p>D1.3.Мэдлэг сорьсон өөрчлөлтийг хурдан мэдэрч үйл ажиллагаандаа тусгах, хэрэгжүүлэх</p> <p>D1.4.Ахисан түвшний сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг манлайлан ажиллах</p>	<p>D2.1. Мэргэжлийн салбарын хүрээнд тулгамдсан асуудлыг тодорхойлон гарц шийдлийг таамаглах, тодорхойлох, шинэ санал санаачлага, концепц гаргах</p> <p>D2.2. Тухайн дэвшүүлсэн санал санаачлага, гарц шийдэлийн талаар шинжлэх ухааны үндэслэлтэй судалгааны төсөл төлөвлөх</p> <p>D2.3. Төслийн санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлох, төслийн багийг бүрдүүлэх, судалгааны багийг нэгдсэн удирдлагаар хангах</p> <p>D2.4. Судалгааны үр дүнг олон улсын түвшинд түгээн дэлгэрүүлэх, шинэ бүтээгдэхүүн, үр өгөөжтэй үйлчилгээ болгон хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, манлайлах</p> <p>D2.5. Судалгааны хүрээнд гадаад дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх</p> <p>D2.6. IF-JCR-тэй олон улсын сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн байх</p>	<p>D3.1.Төсөл хөтөлбөрийн санхүүжилт босгох, гадаадтай хамтарсан төсөл хэрэгжүүлэх, инновацийн бүтээл гаргах, нэвтрүүлэх,</p> <p>D3.2.Эрдэм шинжилгээний бүтээл, ном, сурах бичиг, лабораторийн ажлын заавар, гарын авлага бичих, хэвлүүлэх, үйл ажиллагааг удирдан манлайлах</p> <p>D3.3.Судалгааны шинэ чиглэл гаргах, нэвтрүүлэх</p> <p>D3.4.Судалгааны үр дүн, өгөөжийг хэрэгжүүлэх</p> <p>D3.5.Экологи, байгаль орчин, нийгэмд ээлтэй шинэ мэдлэг, инновацийг бүтээх</p> <p>D3.6.Судалгаа, шинэ бүтээлээ сургалт болон эдийн засгийн эргэлтэд оруулах</p> <p>D3.7.Шинэ бүтээл, шинэ ба шинэчилсэн загвар, шинэ материалыг бий болгох</p> <p>D3.8.Салбар тэнхимээс санаачилж байгаа ажил дээр багш нарын санал хүсэлтийг асууж, хэлэлцүүлдэг өрнүүлдэг байх</p> <p>D3.9.Профессор багш нарт төсөл бичих сургалт зохион байгуулах, хөрөнгө босгох санхүүгийн мэдлэг олгож чадавхжуулах</p>	<p>D4.1. Үндэсний хэмжээнд болон салбар, мэргэжлийн хүрээний бодлогыг боловсруулах, харьцуулсан анализ хийж үнэлэлт дүгнэлт гаргах, инновацийг бий болгох, хөгжүүлэх арга замыг тодорхойлох</p> <p>D4.2. Боловсрол ажил мэргэжлийн салбарын хүрээнд мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулах</p> <p>D4.3. Мэргэжлийн холбоод салбарын хооронд хамтын ажиллагаанд оролцох</p> <p>D4.4. Мэргэжлийн эрдэм шинжилгээний сэтгүүлийг хөгжүүлэх редакц, мэргэжлийн зөвлөлд ажиллах</p> <p>D4.5. Салбарын хөтөлбөрийн чанарыг баталгаажуулах, магадлан итгэмжлэх үйл ажиллагаанд манлайлан идэвхийлэн оролцох</p> <p>D4.6. Тогтвортой хөгжлийг таниулах, хэрэгжүүлэх</p> <p>D4.7. Нийгмийг соён гэгээрүүлэх, нийгмийн сайн сайхны төлөө үйл ажиллагаанд оролцох</p>	<p>D5.1.Суралцагчид болон олон нийтэд зориулсан мэргэжлийн онол-арга зүйн зөвлөмж мэдээлэл бэлтгэх, ажлын арга зүйн зөвлөгөө өгөх</p> <p>D5.2.Судалгааны ажлын үр дүн болон шинжлэх ухааны мэдлэгийг мэргэжлийн салбар, холбоод, төгсөгчид, ажил олгогчдын захиалгаар түгээн дэлгэрүүлэх үйл хийх</p> <p>D5.3.Үйлдвэрлэл, ажлын байран дээр тулгарч буй асуудлуудыг мэргэжлийн зүгээс шийдвэрлэх, үйл ажиллагааг зохион байгуулах, удирдах</p> <p>D5.4.Залуу багш нар, судлаачдыг дэмжин ажиллах, тэднийг чиглүүлэх</p> <p>D5.5.Үндэсний болон салбар, мэргэжлийн хүрээний дүрэм, журам, санал, зөвлөмж, норм, стандарт, арга зүй, аргачлал, тайлан боловсруулах, түгээх, нийтийн хүртээл болгох ажлыг манлайлах</p> <p>D5.6.Сургалтын үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр ажил олгогч, салбар мэргэжлийн түншлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх Мэргэжлийн холбоод салбарын хоорондын хамтын ажиллагаанд идэвхитэй манлайлан оролцох</p>

- - - оОо - - -

Анхан шатны сургалт ба багшийн чадамжийн хамаарал

Чадамж	Сургалтаар эзэмших чадамж буюу багшийн мэдлэг, чадвар	Хичээлийн нэр					
		Боловсролын онол, арга зүй	Суралцахуйн дизайн	Сургалтын технологи арга зүй,	Багшийн МХХИ-ийн чадамжийн тогтолцоо	Нээлтэй боловсрол	Боловсролын сэтгэл судлал, ёс зүй
1. Багшлахуйн чадамж	Философи, сэтгэл судлал, суралцахуйн онол, нейросайнсын мэдлэг	*	*	*	*	*	*
	Суралцахуйн дизайн, сургалтын хөтөлбөр болон хичээлийн хөтөлбөр боловсруулах, хөгжүүлэх	*	*	*			
	Багшлахуйн арга зүй, технологийг эзэмших, хэрэгжүүлэх	*	*	*			
	Багш хамт олон болон суралцагчдад зөвлөх	*		*		*	*
	Нийгмийн болон мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх	*	*	*	*	*	*
	Цахим хэрэглэгдэхүүн болон шинэ дэвшилтэт техник, технологийг хэрэглэх			*	*	*	
Сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах, удирдах	Суралцахуйн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах	*	*	*			
	Суралцагч төвтэй сургалтын орчинг бүрдүүлэх		*			*	
	Үнэлгээ, дүгнэлт хийх		*	*			*
	Сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэх, хэрэглэх				*	*	
3. Хувь хүний манлайллын чадамж	Сургалт, үйлдвэрлэл, нийгмийн болон мэргэжлийн үйлчилгээг хослуулан гүйцэтгэх	*			*	*	*
	Харилцааны болон зөв хандлагатай байх	*	*	*	*	*	*
	Бусдыг ойлгох, сэтгэл хөдлөлөө удирдах, тэвчээр, хатуужилтай байх						*
	Асуудлыг цогцоор нь шийдвэрлэх	*	*	*	*		
	Системийн сэтгэлгээтэй байх	*	*	*	*		*
	Ёс зүйтэй байх						*
Хувь хүний ур чадвар	Бүтээлч, шинийг эрэлхийлэгч байх					*	*
	Манлайлах удирдан чиглүүлэх	*	*	*	*	*	*
	Насан туршийн суралцагч байх					*	
	Хувь хүний болон байгууллагын нууцыг хадгалах					*	*
	Цаг менежменттэй байх						
Техникийн ур чадвар	Үндэсний уламжлал, соёлыг дээдэлдэг байх						*
	Багаар ажиллах						*
	Бичиг баримтыг боловсруулах						
	Санхүү менежментээ зөв удирдах						
	Дижитал ур чадвар (сошиал медиа, дата аналитик, видео)-аа ашиглах				*	*	*
Мэргэжлийн мэдлэг оюунаа ашиглах	*	*	*				

Дунд шатны сургалт ба багшийн чадамжийг дэмжих хамаарал

Чадамж	Сургалтаар эзэмших чадамж буюу багшийн мэдлэг, чадвар	Хичээлийн нэр								
		Боловсролын хөтөлбөрийг боловсруулах	Хөтөлбөрийн дизайн боловсруулалт	Хөтөлбөрийн үнэлгээ	Цахим сургалтын арга	Нээлтэй нөөц эх материал	Судалгааны арга зүй	Судалгааны бичиг баримт	Зөвлөн ур чадварын	Бүтээлч ур чадварын хөгжил
1. Багшлахуйн чадамж	Философи, сэтгэл судлал, суралцахуйн онол, нейросайнсын мэдлэг	*	*	*	*	*	*	*	*	*
	Суралцахуйн дизайн, сургалтын хөтөлбөр болон хичээлийн хөтөлбөр боловсруулах, хөгжүүлэх	*	*	*	*					
	Багшлахуйн арга зүй, технологийг эзэмших, хэрэгжүүлэх				*	*	*		*	*

		Багш хамт олон болон суралцагчдад зөвлөх								*		
		Нийгмийн болон мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх			*						*	
		Цахим хэрэглэгдэхүүн болон шинэ дэвшилтэт техник, технологийг хэрэглэх				*	*					
		Суралцахуйн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах									*	
		Суралцагч төвтэй сургалтын орчинг бүрдүүлэх					*				*	*
		Үнэлгээ, дүгнэлт хийх	*	*								
Сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах	Сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэх, хэрэглэх				*	*					*	
	Сургалт, үйлдвэрлэл, нийгмийн болон мэргэжлийн үйлчилгээг хослуулан гүйцэтгэх		*							*	*	
	Оюуны өмчийн хууль эрх зүйн мэдлэг					*	*	*	*	*	*	
	Судалгааны онол, арга зүйтэй байх						*	*	*	*	*	
	Судлаачийн ёс зүйтэй байх						*	*	*			
	Судалгааны програм хангамж, техник технологийг эзэмшсэн байх					*		*				
Судалгааны онол, арга зүйн чадвар	Оюуны өмчийг эзэмших, ашиглах					*	*	*	*			
	ШУ-ны шинэ чиглэл, ололт онолыг эрэлхийлэх, эзэмших					*					*	
	Судалгааны үр дүнгээр өгүүлэл, тайлан бичих					*	*	*			*	
	Судалгааг хэвлэн нийтлэх түгээн дэлгэрүүлэх									*	*	
	Интерпретер, судалгаа, төслийн эх үүсвэр, санхүүжилт бүрдүүлэх, гарааны компани байгуулах									*	*	
	Судалгаа, төсөл, хөтөлбөрийн хүрээнд судлаачийг удирдах									*	*	
Судалгааны ажлын менежмент	Судалгаа, төсөл, хөтөлбөрийг удирдах, хэрэгжүүлэх, оролцох					*	*	*	*	*	*	
	Харилцааны болон зөв хандлагатай байх									*		
	Бусдыг ойлгох, сэтгэл хөдлөлөө удирдах, тэвчээр, хатуужилтай байх									*	*	
	Асуудлыг цогцоор нь шийдвэрлэх									*	*	
	Системийн сэтгэлгээтэй байх	*	*	*	*	*	*	*	*	*	*	
	Ёс зүйтэй байх	*	*	*	*	*	*	*	*	*		
Зөөлөн ур чадвар	Бүтээлч, шинийг эрэлхийлэгч байх	*	*		*		*				*	
	Манлайлах удирдан чиглүүлэх	*	*	*	*					*		
	Насан туршийн суралцагч байх				*	*	*	*	*	*	*	
	Хувь хүний болон байгууллагын нууцыг хадгалах									*		
	Цаг менежменттэй байх									*		
	Үндэсний уламжлал, соёлыг дээдэлдэг байх									*		
Хувь хүний ур чадвар	Багаар ажиллах									*		
	Бичиг баримтыг боловсруулах	*	*						*		*	
	Санхүү менежментээ зөв удирдах									*	*	
	Дижитал ур чадвар (сошиал медиа, дата аналитик, видео)-аа ашиглах				*	*					*	
	Мэргэжлийн мэдлэг оюунаа ашиглах	*	*	*	*		*	*				

Ахисан шатны сургалт ба багшийн чадамжийг дэмжих хамаарал

Чадамж	Сургалтаар эзэмших чадамж буюу багшийн мэдлэг, чадвар	Хичээлийн нэр									
		ҮДСБ-ын онол, арга зүй	Хөтөлбөр хөгжүүлэх арга зүй	Сургалтын дотоод чанарын баталгаажуулалт	Дижитал шилжилт	Нээлттэй шинжлэх ухаан	Судалгааны менежмент	Судалгааны үр дүнг түгээн дэлгэрүүлэх арга зүй	Манлайлал	Карьер хөгжил	
1. Багшлахуйн чадамж	Багшийн мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх	Философи, сэтгэл судлал, суралцахуйн онол, нейросайнсын мэдлэг	*	*	*	*	*	*	*	*	
		Суралцахуйн дизайн, сургалтын хөтөлбөр болон хичээлийн хөтөлбөр боловсруулах, хөгжүүлэх	*	*	*	*	*				
		Багшлахуйн арга зүй, технологийг эзэмших, хэрэгжүүлэх	*	*	*	*	*				
		Багш хамт олон болон суралцагчдад зөвлөх	*	*	*	*	*	*	*	*	
		Нийгмийн болон мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх	*	*	*	*	*	*		*	
		Цахим хэрэглэгдэхүүн болон шинэ дэвшилтэт техник, технологийг хэрэглэх				*					
	Сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах	Суралцахуйн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах			*					*	*
		Суралцагч төвтэй сургалтын орчинг бүрдүүлэх	*							*	
		Үнэлгээ, дүгнэлт хийх	*	*	*						
		Сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэх, хэрэглэх		*			*	*	*		
	Сургалт, үйлдвэрлэл, нийгмийн болон мэргэжлийн үйлчилгээг хослуулан гүйцэтгэх		*	*			*		*	*	
2. Судалгаа, инновацийн чадамж	Судалгааны онол, арга зүйн чадвар	Оюуны өмчийн хууль эрх зүйн мэдлэг				*	*	*	*	*	*
		Судалгааны онол, арга зүйтэй байх						*	*	*	*
		Судлаачийн ёс зүйтэй байх						*	*	*	
		Судалгааны програм хангамж, техник технологийг эзэмшсэн байх				*	*		*		
		Оюуны өмчийг эзэмших, ашиглах					*	*	*	*	*
		ШУ-ны шинэ чиглэл, ололт онолыг эрэлхийлэх, эзэмших							*	*	*
	Судалгааны ажлын менежмент	Судалгааны үр дүнгээр өгүүлэл, тайлан бичих					*	*	*		
		Судалгааг хэвлэн нийтлэх түгээн дэлгэрүүлэх						*	*		
		Судалгаа, төслийн эх үүсвэр, санхүүжилт бүрдүүлэх, гарааны компани байгуулах						*		*	*
		Судалгаа, төсөл, хөтөлбөрийн хүрээнд судлаачийг удирдах						*		*	
	Судалгаа, төсөл, хөтөлбөрийг удирдах, хэрэгжүүлэх, оролцох					*	*		*	*	
3. Хувь хүний манлайллын чадамж	Зөөлөн ур чадвар	Харилцааны болон ёс зүйн зөв хандлагатай байх								*	*
		Бусдыг ойлгох, сэтгэл хөдлөлөө удирдах, тэвчээр, хатуужилтай байх									
		Асуудлыг цогцоор нь шийдвэрлэх						*	*	*	*
		Системийн сэтгэлгээтэй байх	*	*	*	*	*	*	*	*	*
		Ёс зүйтэй байх						*	*	*	*
		Бүтээлч, шинийг эрэлхийлэгч байх						*	*	*	*
	Хувь хүний ур чадвар	Манлайлах удирдан чиглүүлэх	*	*	*	*	*	*	*	*	*
		Насан туршийн суралцагч байх							*		*
		Хувь хүний болон байгууллагын нууцыг хадгалах								*	
		Цаг менежменттэй байх						*		*	*
Техникийн ур чадвар	Үндэсний уламжлал, соёлыг дээдэлдэг байх								*	*	
	Багаар ажиллах		*	*					*	*	
	Бичиг баримтыг боловсруулах		*	*				*			

	Санхүү менежментээ зөв удирдах						*		*	*
	Дижитал орчин (сошиал медиа, дата аналитик, видео, апп, EduTech)-д ажиллах				*	*		*		
	Мэргэжлийн мэдлэг оюунаа хөгжүүлэх		*	*			*	*	*	*

--- оОо ---

ПРОФЕССОР БАГШ НАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ НИЙТЛЭГ ШАЛГУУР, ҮНЭЛЭХ ҮЗҮҮЛЭЛТ

Чанарын үнэлгээний оноо:

1-Хангалтгүй, 2-Сайжруулах шаардлагатай, 3-Боломжийн, 4-Хангалттай сайн

Нэг. Сургалтын үйл ажиллагааны үнэлгээ

Зэрэглэл	Нийтлэг шаардлагын дагуу үнэлэгдэх үйлүүд (код, үйл ажиллагаа)	Үнэлгээний нийтлэг шалгуур	Нотлох баримт	Үнэлэх үзүүлэлт (тоон үнэлгээ)	Чанарын үнэлгээ (1-4 оноо)
Дадлагдажигч багш	1. Хичээлийн хөтөлбөр, сургалтын үйл ажиллагаанд оролцох	Боловсруулсан хичээлийн хөтөлбөр Заасан хичээлийн үр дүн	Мэргэжлийн тэнхимийн хөтөлбөр боловсруулсан талаарх бүртгэл	Боловсруулахад оролцсон хөтөлбөрийн тоо	
	2. Хичээлийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх ажлыг хийх	Заадаг хичээлийн дизайн төлөвлөлтийг хийсэн байдал Өөрийн болоод хамт олны сэтгэл ханамжийн байдал	Заасан хичээлийн үр дүнгийн тайлан Өдөр тутмын үйл ажиллагаа	Өөрийн сэтгэл ханамжийн түвшин Оюутны сэтгэл ханамжийн түвшин	
	3. Суралцагчийг сургалтын үйл ажиллагаа болон нийгмийн хариуцлагатай байдалд чиглүүлэх	Оюутны сэтгэл ханамжийн байдал	Оюутны сэтгэл ханамжийн судалгаа	Оюутны сэтгэл ханамжийн түвшин	
	4. Суралцагчийг үнэлэх үнэлгээний аргачлалыг төлөвлөх, дүн шинжилгээ хийхэд салбарын эрхлэгчтай хамтран ажиллах Сургалтын орчныг зөв зохистой төлөвлөх	Суралцагчдыг үнэлэх арга нь хичээлийн зорилгод нийцсэн байдал	Суралцагчдыг үнэлэх үнэлгээний матриц, удирдамж, бусад хэрэглэгдэхүүн	Оюутны багшийн үнэлгээнд өгсөн сэтгэл ханамжийн түвшин, Үнэлгээний бодит чанар	
Багш	1. Сургалтын болон хичээлийн хөтөлбөр боловсруулан, хэрэгжүүлэх	Сургалтын хөтөлбөр боловсруулсан байдал Хичээлийг сайжруулах талаар анхаарсан байдал Хичээлийн үр дүнг үнэлсэн байдал	Боловсруулсан бичиг баримт Хөтөлбөрт өгсөн оюутны сэтгэл ханамжийн судалгааны тайлан Заасан хичээлийн үр дүн	Боловсруулсан хөтөлбөрийн чанарын баталгаажуулалт Хичээлд өгсөн оюутны сэтгэл ханамжийн түвшин	
	2. Сургалтын орчныг сайжруулах шинэлэг бүтээлч нөхцөлийг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулах	Сургалтын явц, үр дүн Сургалтын арга хэлбэрүүдийн үр дүнг харьцуулан дүгнэсэн байдал	Сургалтад шинэлэг арга зүй, дэвшилтэт, дижитал технологи, программ хангамжийг ашигласан байдал	Сургалтад хэрэглэсэн арга зүйн төрөл, хэлбэр, тоо Оюутны суралцахуйн үр дүн	
	3. Суралцагчийн ухамсартай сурах үйл явцыг чиглүүлэн удирдаж, зохион байгуулах	Оюутантай ажилладаг байдал	Сургалтаа зохион байгуулж байгаа байдал	Хамтран ажиллаж буй багш, оюутны сэтгэл ханамжийн түвшин	
	4. Хичээлийн болон сургалтын хөтөлбөрийн хүрээнд суралцагчийг үнэлэх аргачлалыг хэрэгжүүлэх, дүгнэлт гаргах	Сургалтынхаа орчныг сайжруулах талд санаачилга гаргадаг байдал	Бүтээлчээр бий болгосон сургалтын орчин	Сургалтын орчин бүрдлийн бодит байдлын түвшин	
	5. Сургалтанд шинэ дэвшилтэт технологи, арга зүй, аргачлалыг турших, нэвтрүүлэх	Суралцагчдыг үнэлж дүгнэж, тэдэнтэй ажилладаг арга барил, тэдний сэтгэл ханамжийн байдал	Шалгалт авах, зөвлөгөө өгөх ажлын явц, байдал, Суралцагчдын сэтгэл ханамжийн судалгаа Үнэлгээний сан	Үнэлгээний чанар, бодит байдлын түвшин Оюутны сэтгэл ханамжийн түвшин	
	6. Өөрийн мэдлэг чадварыг тасралтгүй хөгжүүлэх, мэргэжлийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэх	Өөрийн хөгжлийн төлөвлөгөөтэй ажилладаг байдал	Өөрийн хөгжлийн төлөвлөгөө, хэрэгжилтийн тайлан	Төлөвлөгөөнд тусгасан ажлын хэрэгжилтийн түвшин	
Ахла	1. Сургалтын болон хичээлийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, хөтөлбөрийг тасралтгүй сайжруулах	Боловсруулсан хичээлийн хөтөлбөр	Мэргэжлийн тэнхимийн хөтөлбөр боловсруулсан талаарх бүртгэл	Боловсруулахад оролцсон хөтөлбөрийн тоо	

		Заасан хичээлийн үр дүн			
	2. Сургалтын орчныг сайжруулах арга замыг хайх, төлөвлөх	Дадлагажигч багшид зөвлөн тусалж ажилладаг байдал	Дадлагажигч багшийн хөгжил, төлөвшлийн түвшин	Дадлагажигч багшийн төлөвшлийн түвшин, сэтгэл ханамж	
	3. Суралцагчийн сурах үйл явцад дүн шинжилгээ хийх, үр дүнгээр нь санал дүгнэлт гаргах	Багаа удирдан ажиллаж байгаа байдал	Багийн ажлын тайлан, бодит байдал	Багийн ажлын чанар, үр дүн	
	4. Сургалтанд шинэ дэвшилтэт технологи, арга зүйн шилдэг туршлагыг санаачлах, хэрэгжүүлэх	Тухайн чиглэлийн ажлыг санаачилсан, хэрэгжүүлсэн байдал	Ажлын тайлан, оролцсон байдлыг илэрхийлэх тушаал, шийдвэр, баримт бичиг	Оролцсон ажлын үр өгөөж Боловсруулсан бичиг баримтын хэрэгжсэн байдал	
	5. Суралцагчийг үнэлэх үнэлгээний шинэ дэвшилтэт аргачлалыг сургалтанд хэрэгжүүлэн, гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх	Суралцагчдыг үнэлэх арга нь хичээлийн зорилгод нийцсэн байдал	Суралцагчдыг үнэлэх үнэлгээний матриц, удирдамж, бусад хэрэглэгдэхүүн	Оюутны багшийн үнэлгээнд өгсөн сэтгэл ханамжийн түвшин, Үнэлгээний бодит чанар	
	6. Сургалтын болон мэргэжлийн ажлын баг удирдан ажиллах	Багаа удирдан ажиллаж байгаа байдал	Багийн ажлын тайлан, бодит байдал	Багийн ажлын чанар, үр дүн	
Дэд профессор	1. Сургалтын болон хичээлийн хөтөлбөр боловсруулах ажлыг удирдан чиглүүлэх, манлайлах	Боловсруулсан хичээлийн хөтөлбөр Заасан хичээлийн үр дүн	Мэргэжлийн тэнхимийн хөтөлбөр боловсруулсан талаарх бүртгэл	Боловсруулахад оролцсон хөтөлбөрийн тоо	
	2. Сургалт, судалгааны орчныг сайжруулах, шинээр байгуулах чиглэлээр манлайлан ажиллах	Тухайн чиглэлийн ажилд оролцож байгаа байдал	Ажлын тайлан, холбогдох баримт бичиг	Оролцсон ажлуудын тоо, хувь	
	3. Багшлах бүрэлдэхүүний чадварыг сайжруулах, хөгжүүлэхэд манлайлан ажиллах	Хамт олныг удирдан ажиллаж байгаа байдал	Ажлын тайлан, холбогдох баримт бичиг	Хамт олны үнэлгээ Тухайн хамт олны ажлын үр дүн, чанар	
	4. Салбар дундын, хамтарсан хөтөлбөр боловсруулах чиглэлээр тэнхим гадаад, дотоодын их сургуультай хамтран түүчээлэн ажиллах	Боловсруулсан хөтөлбөр	Хөтөлбөрийн баримт бичиг	Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалт Хамтрагчдын сэтгэл ханамжийн түвшин	
	5. Багшлах, суралцахуйн заах арга зүйн мэдлэг, ур чадвараа түгээн дэлгэрүүлэх туршлагаа хуваалцахад манлайлах	Тухайн чиглэлийн ажлыг санаачилсан, удирдсан, манлайлсан байдал	Ажлын тайлан, оролцсон байдлыг илэрхийлэх тушаал, шийдвэр, баримт бичиг	Оролцсон ажлын үр өгөөж Боловсруулсан бичиг баримтын хэрэгжсэн байдал	
	6. Хөтөлбөрийг бүтнээр нь үнэлэх арга зүйг хэрэгжүүлэн чанарын баталгаажуулалтыг нэвтрүүлэн, үр дүнгийн гүйцэтгэлд дүнд шинжилгээ хийх, хөтөлбөрийн сайжруулалтанд тусгах, манлайлах	Сургалтын чиглэлд шинээр туршиж хэрэгжүүлсэн инновац	Инновацийн бүтээл	Бүтээлийн чанар, хэрэгжүүлсэн байдал	
		Багшлахуй, суралцахуй заах арга зүйн чиглэлээр хэрэгжүүлсэн байдал	Ажлын тайлан, холбогдох баримт бичиг	Сайн туршлага дэлгэрсэн байдал Мэргэжлийн баг, хамт олны сэтгэл ханамж	
Профессор	1. Тогтвортой хамтын ажиллагаа, стратегийн түншлэлээр дамжуулан сургалтын хөтөлбөрийг сайжруулж, салбарын хөгжлийн ирээдүйг тодорхойлох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх	Боловсруулсан хичээлийн хөтөлбөр Заасан хичээлийн үр дүн	Мэргэжлийн тэнхимийн хөтөлбөр боловсруулсан талаарх бүртгэл	Боловсруулахад оролцсон хөтөлбөрийн тоо	
	2. Сургалтанд чанарын удирдлагыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг манлайлах	Тухайн чиглэлийн ажлыг санаачилсан, удирдсан, манлайлсан байдал	Ажлын тайлан, оролцсон байдлыг илэрхийлэх тушаал, шийдвэр, баримт бичиг	Оролцсон ажлын үр өгөөж Боловсруулсан бичиг баримтын хэрэгжсэн байдал	
	3.				
	4. Мэдлэг сорьсон өөрчлөлтийг хурдан мэдэрч үйл	Тухайн чиглэлийн ажлыг	Ажлын тайлан, оролцсон байдлыг	Оролцсон ажлын үр өгөөж	

	ажиллагаандаа тусгах, хэрэгжүүлэх	санаачилсан, удирдсан, манлайлсан байдал	илэрхийлэх тушаал, шийдвэр, баримт бичиг	Боловсруулсан бичиг баримтын хэрэгжсэн байдал
5.	Ахисан түвшний сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг манлайлан ажиллах	Тухайн чиглэлийн ажлыг санаачилсан, удирдсан, манлайлсан байдал	Ажлын тайлан, холбогдох баримт бичиг Шинээр нээсэн хөтөлбөрийн баримт бичиг	Бодит үр дүн, арга туршлагын түвшин

Хоёр. Судалгаа-инновацийн үйл ажиллагааны үнэлгээ

Зэрэглэл	Нийтлэг шаардлагын дагуу үнэлэгдэх үйлүүд (код, үйл ажиллагаа)	Үнэлгээний нийтлэг шалгуур	Нотлох баримт	Үзүүлэлт (Тоог үнэлгээ)	Чанарын үнэлгээ
Дадлагажигч багш	1. Салбар шинжлэх ухаан, мэргэжлийн чиглэлээр судалгаа хийх	Хөгжлийн төлөвлөгөөндөө тусгаж хэрэгжүүлдэг байдал	Ажлын төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн тайлан	Хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүн	
	2. Шинжлэх ухааны бүтээлийг хайх, унших, боловсруулах, нэгтгэн дүгнэх	Судалгааны ажилд оролцож байгаа байдал	Судалгааны ажлын тайлан, бүтээл	Судалгааны үр дүн, хамтын бүтээлийн чанар, тоо	
	3. Туршилт судалгаа төлөвлөх, судалгааны арга зүйг эзэмших	Судалгааны арга зүйд суралцсан байдал Бүтээл туурвиж буй байдал	Сургалтад хамрагдсан нотолгоо Туурвисан бүтээл	Судалгааны бүтээлийн тоо, чанар	
	4. Туршилт хийх, судалгааны өгөгдлийг цуглуулах, мэдээллийг боловсруулах, тайлбарлах	Тухайн чиглэлийн ажилд оролцож байгаа байдал	Ажлын тайлан, холбогдох баримт бичиг	Оролцсон ажлуудын тоо, хувь	
	5. Судалгааны үр дүнг түгээн дэлгэрүүлэх ажилд туслах	Тухайн чиглэлийн ажилд оролцож байгаа байдал	Ажлын тайлан, холбогдох баримт бичиг	Оролцсон ажлуудын тоо, хувь	
	6. Судалгаа эрдэм шинжилгээний өгүүлэл бичих, хэвлүүлдэхэд суралцах				
	7. Сургалтанд инновац хэрэглэх				
	8. Судалгааны үр дүн, өгөөжийг ашиглах				
	9. Экологи, байгаль орчин, нийгэмд ээлтэй шинэ мэдлэг, инновацийг судлах, бүтээхэд эрмэлзэх				
	10. Салбар тэнхимээс санаачилж байгаа ажилд идэвхитэй оролцох				
Багш	1. Үндэсний болон олон улсын хэмжээнд судалгаа хийх	Судалгааны ажил хийсэн байдал	Судалгааны ажлын тайлан мэдээ	Судалгааны тоо, Оролцооны үүрэг, чанар	
	2. Судалгааны өгөгдлийг нэгтгэх, боловсруулах, дүн шинжилгээ хийх, нэгтгэн дүгнэх, тайлагнах				
	3. Судлаач оюутнуудыг бэлтгэх, зөвлөх, сургах				
	4. Эрдэм шинжилгээний бүтээл ном, сурах бичиг, лабораторийн ажлын заавар, гарын авлага бичих, хэвлүүлэх				
	5. Гадаад болон дотоодын эрдэм шинжилгээний хуралд оролцох, судалгааны ажлын үр дүнг түгээн дэлгэрүүлэх				
	6. Сургалтанд инновац хэрэглэх				
	7. Судалгааны үр дүн, өгөөжийг хэрэглэх	Бусдад зөвлөн туслах ажлын арга барил эзэмшсэн байдал	Зөвлөн тусалсан дадлагажигч багш болон оюутны судалгааны ажил, бүтээл	Дадлагажигч багш нар болон оюутны сэтгэл ханамжийн түвшин Хэвлүүлсэн бүтээлийн тоо, чанар	

	8. Экологи, байгаль орчин, нийгэмд ээлтэй шинэ мэдлэгийг эзэмших	Эрдэм шинжилгээний бүтээл бичих, хэвлэлтэд бэлтгэх чадварын төлөвшил	Бичиж боловсруулсан болон хэлэлцүүлсэн бүтээл	Бүтээлийн тоо, чанар	
	9. Инновацийг ойлгох, таньж мэдэх, хийхээр эрмэлзэх, хийх	Ажлын арга туршлага эзэмшиж байгаа байдал	Оролцсон үйл ажиллагааны тухай тайлан, мэдээлэл	Оролцсон үйл ажиллагааны тоо, үр дүн	
	10. Салбар тэнхимээс санаачилж байгаа ажилд идэвхитэй оролцох				
Ахлах багш	1. Судалгааны баг, судлаач, оюутныг удирдан чиглүүлэх	Багшийнхтай адил	Багшийнхтай адил	Багшийнхтай адил	
	2. Судалгааны ажил бие даан гүйцэтгэх	Баг, судлаачидтайгаа ажиллаж байгаа байдал	Ажлын тайлан, бүтээл	Ажлын үр дүн, бүтээлийн тоо, чанар	
	3. Судалгааны арга зүйг түгээн дэлгэрүүлэх				
	4. Төслийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг хариуцан ажиллах	Үндэсний хэмжээнд төсөл, хөтөлбөр боловсруулсан байдал	Төслийн бичиг баримт Гаргасан санал	Боловсруулсан төсөл, хөтөлбөрийн тоо, чанар	
	5. Судлаач, дадлагажигч багш болон багшийг дэмжин чиглүүлж ажиллах				
	6. Олон улсын болон үндэсний түвшинд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн санал боловсруулах, бичиг баримт бүрдүүлэх	Хэрэгжүүлсэн судалгааны ажил	Ажлын тайлан, бүтээл	Судалгааны төслийн үр дүн, бүтээлийн тоо, чанар	
	7. Эрдэм шинжилгээний бүтээл ном, сурах бичиг, лабораторийн ажлын заавар, гарын авлага бичих, хэвлүүлэх				
	8. Сургалт, уйлдвэрлэлийн холбоог бэхжүүлэх, судалгааны ажлын ур дүнгээр эрдэм шинжилгээний хурал, үзэсгэлэн зохион байгуулахад оролцох				
	9. Сургалтанд инновацийг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх				
	10. Экологи, байгаль орчин, нийгэмд ээлтэй шинэ мэдлэг, инновацийг бүтээх				
	11. Инновацлаг санал санаачлага гаргах				
	12. Төсөл хөтөлбөрийн санхүүжилтийг бий болгох, бүрдүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэхэд хамтарч ажиллах	Харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлсэн байдал	Хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээр, санхүүгийн тайлан	Хамтын ажиллагааны үр дүн, Санхүүжилтийн хэмжээ	
Дэд профессор	1. Төсөл хөтөлбөрийн санал боловсруулах, төслийн бичиг баримт бүрдүүлэх ажлыг удирдан манлайлах	Төслийн баг, судлаачидтайгаа ажиллаж байгаа байдал	Ажлын тайлан, бүтээл	Багийн ажлын үр дүн, багийн гишүүдийн сэтгэл ханамжийн түвшин	
	2. Хэрэгжүүлж буй эрдэм шинжилгээ судалгааны төслийг гүйцэтгэх, удирдах, санал, үндэслэлээ гаргах	Үндэсний болон олон улсын хэмжээнд төсөл, хөтөлбөр боловсруулсан, хэрэгжүүлсэн байдал	Төслийн бичиг баримт	Боловсруулсан төсөл, хөтөлбөрийн тоо, чанар	
	3. Төслийн баг болон судлаачдад дэмжлэг үзүүлэх, манлайлан ажиллах	Судалгааны төсөл хэрэгжүүлсэн байдал, ач холбогдлын хүрээ	Төслийн тайлан, бүтээл	Төслийн ажлын тоо, үр дүн, бүтээлийн тоо, чанар	
	4. Бодлогын бичиг баримт боловсруулах, санал дэвшүүлэх	Санхүүжилт бүрдүүлсэн байдал	Хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээр, санхүүгийн тайлан	Төслийн ажлын тоо, үр дүн, чанар Санхүүжилтийн хэмжээ	
	5. Эрдэм шинжилгээний бүтээл, ном, сурах бичиг,				

	лабораторийн ажлын заавар, гарын авлага бичих, хэвлүүлэх, үйл ажиллагааг удирдан манлайлах				
	6. Судалгааны бүтээлийг хянан магадлах үйл ажиллагаанд оролцож, судалгааны чанарыг өндөрт хадгалахад хувь нэмэрээ оруулах				
	7. Мэдлэг сорьсон өөрчлөлтийг мэдэрч үйл ажиллагаанд тусгах, тэргүүлэх				
Профессор	1. Мэргэжлийн салбарын хүрээнд тулгамдсан асуудлыг тодорхойлон гарц шийдлийг таамаглах, тодорхойлох, шинэ санал санаачлага, концепц гаргах	Төслийн баг, судлаачидтайгаа ажиллаж байгаа байдал	Ажлын тайлан, бүтээл	Багийн ажлын үр дүн, багийн гишүүдийн сэтгэл ханамжийн түвшин	
	2. Тухайн дэвшүүлсэн санал санаачлага, гарц шийдэлийн талаар шинжлэх ухааны үндэслэлтэй судалгааны төсөл төлөвлөх	Мэргэжлийн салбарын асуудлыг шийдвэрлэсэн байдал Шинэ санаа гаргасан байдал	Ажлын тайлан, бүтээл	Гаргасан санал, төслийн ажлын хэрэгжилтийн үр дүн, чанар Гадаад, дотоод хамтын ажиллагаанд оруулж буй хувь нэмрийн түвшин	
	3. Төслийн санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлох, төслийн багийг бүрдүүлэх, судалгааны багийг нэгдсэн удирдлагаар хангах	Судалгааны төсөл төлөвлөсөн байдал	Судалгааны төсөл	Төслийн тоо, чанар, шинэлэг байдал	
	4. Судалгааны үр дүнг олон улсын түвшинд түгээн дэлгэрүүлэх, шинэ бүтээгдэхүүн, үр өгөөжтэй үйлчилгээ болгон хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, манлайлах	Судалгааны төслийг хэрэгжүүлж буй байдал Төслийн удирдлагын төлөвлөлт	Төслийн хэрэгжилтийн тайлан Санхүүгийн тайлан	Төслийн тоо Санхүүжилтийн хэмжээ	
	5. Судалгааны хүрээнд гадаад дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх	Судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлсэн байдал	Гарааны компани Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, инновац	Инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо Оюуны өмчийн эрхийн баталгаажилт	
	6. IF-JCR-тэй олон улсын сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн байх	Гадаад, дотоод хамтын ажиллагааг хөгжүүлсэн байдал	Хамтын ажиллагааны санамж бичиг, гэрээ, хамтарсан төсөл, хөтөлбөрийн бичиг баримт	Гадаад хамтын ажиллагааны тоо, түвшин Дотоод хамтын ажиллагааны тоо, түвшин	
	7. Төсөл хөтөлбөрийн санхүүжилт босгох, гадаадтай хамтарсан төсөл хэрэгжүүлэх, инновацийн бүтээл гаргах, нэвтрүүлэх,	Гадаад, дотоод хамтын ажиллагааг хөгжүүлсэн байдал	Хамтын ажиллагааны санамж бичиг, гэрээ, хамтарсан төсөл, хөтөлбөрийн бичиг баримт	Гадаад хамтын ажиллагааны тоо, түвшин Дотоод хамтын ажиллагааны тоо, түвшин	
	8. Эрдэм шинжилгээний бүтээл, ном, сурах бичиг, лабораторийн ажлын заавар, гарын авлага бичих, хэвлүүлэх, үйл ажиллагааг удирдан манлайлах				
	9. Судалгааны шинэ чиглэл гаргах, нэвтрүүлэх	Судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлсэн байдал	Гарааны компани Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, инновац	Инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо Оюуны өмчийн эрхийн баталгаажилт	
	10. Судалгааны үр дүн, өгөөжийг хэрэгжүүлэх	Судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлсэн байдал	Гарааны компани Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, инновац	Инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо Оюуны өмчийн эрхийн баталгаажилт	
	11. Экологи, байгаль орчин, нийгэмд ээлтэй шинэ мэдлэг, инновацийг бүтээх	Судалгааны төсөл төлөвлөсөн байдал	Судалгааны төсөл	Төслийн тоо, чанар, шинэлэг байдал	

	12. Судалгаа, шинэ бүтээлээ сургалт болон эдийн засгийн эргэлтэд оруулах	Судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлсэн байдал	Гарааны компани Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, инновац	Инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо Оюуны өмчийн эрхийн баталгаажилт	
	13. Шинэ бүтээл, шинэ ба шинэчилсэн загвар, шинэ материалыг бий болгох	Судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлсэн байдал	Гарааны компани Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, инновац	Инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо Оюуны өмчийн эрхийн баталгаажилт	
	14. Салбар тэнхимээс санаачилж байгаа ажил дээр багш нарын санал хүсэлтийг асууж, хэлэлцүүлэг өрнүүлдэг байх	Санаачилсан ажлын хэрэгжилт	Хэлэлцүүлгийн тоо, оролцсон багшийн тоо		
	15. Профессор багш нарт төсөл бичих сургалт зохион байгуулах, хөрөнгө босгох санхүүгийн мэдлэг олгож чадавхжуулах	Сургалтын үр дүнг нэвтрүүлж хэрэгжүүлсэн байдал	Сургалтын тоо, үр дүнтэй нэвтрүүлж хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн тоо		

Гурав. Мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний үнэлгээ

	Нийтлэг шаардлагын дагуу үнэлэгдэх үйлүүд (код, үйл ажиллагаа)	Үнэлгээний нийтлэг шалгуур	Нотлох баримт	Үзүүлэлт (Тоон үнэлгээ)	Чанарын үнэлгээ
Дарлагажигч багш	1. Суралцагч болон олон нийтэд зориулсан мэргэжлийн чиглэлийн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд оролцох	Тухайн чиглэлийн үйл ажиллагаанд оролцож байгаа байдал	Ажлын тайлан мэдээлэл	Гүйцэтгэсэн үүрэг, үр дүн Дэмжлэг, зөвлөгөө авсан суралцагчид, хамт олны сэтгэл ханамжийн түвшин	
	2. Суралцагчдад чиглэсэн мэргэжлийн, нийгмийн болон олон нийтийн үйл ажиллагааг зохион байгуулах	Зохион байгуулсан ажлууд	Ажлын тайлан	Зохион байгуулсан ажлуудын тоо, үр дүн, үр өгөөж Зохион байгуулагчийн үнэлгээ, оролцогчдын сэтгэл ханамжийн түвшин	
	3. Нийгэм болон олон нийтэд чиглэсэн сайн дурын үйл ажиллагаанд оролцох	Зохион байгуулсан ажлууд	Ажлын тайлан	Зохион байгуулсан ажлуудын тоо, үр дүн, үр өгөөж Зохион байгуулагчийн үнэлгээ, оролцогчдын сэтгэл ханамжийн түвшин	
	4. Өөрийн мэдлэг чадварыг тасралтгүй хөгжүүлэх, мэргэжлийн үйл ажиллагаа руу чиглүүлэхэд оролцох	Зохион байгуулсан ажлууд	Ажлын тайлан	Зохион байгуулсан ажлуудын тоо, үр дүн, үр өгөөж Зохион байгуулагчийн үнэлгээ, оролцогчдын сэтгэл ханамжийн түвшин	
	5. Суралцагч болон олон нийтэд зориулсан мэргэжлийн чиглэлийн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд оролцох	Оролцсон ажлууд	Оролцсон ажлын тайлан, мэдээлэл	Оролцсон ажлын тоо, үр дүн, зохион байгуулагчийн үнэлгээ, оролцогчдын сэтгэл ханамжийн түвшин	
Багш	1. Салбар мэргэжлийн чиглэлээр иргэдийн мэдлэг, чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн боловсролын үйлчилгээг зохион байгуулах	Оролцсон ажлуудад гүйцэтгэсэн үүрэг	Оролцсон ажлын тайлан, мэдээлэл	Оролцсон ажлын тоо, гүйцэтгэсэн үүргийн чанар, оролцогчдын сэтгэл ханамжийн түвшин	
	2. Мэргэжлийн холбоод, салбарт байгаа мэргэжилтэнүүдийн хоорондын хамтын үйл ажиллагаанд идэвхи санаачлагатай оролцох	Зохион байгуулсан үйл ажиллагааны шинэлэг, үр өгөөжийн байдал	Зохион байгуулсан ажлуудын тайлан, мэдээлэл	Зохион байгуулсан ажлуудын тоо, үр өгөөж Оролцогчдын сэтгэл ханамжийн түвшин	
	3. Нийгмийг соён гэгээрүүлэх, нийгмийн сайн сайхны төлөө сайн дурын үйл ажиллагаанд оролцох	Оролцсон байдал	Оролцсон ажлуудын тухай тайлан мэдээлэл	Оролцсон ажлын тоо, гүйцэтгэсэн үүрэг Хамтран ажиллагчдын түүний оролцооны талаарх үнэлгээ/сэтгэл ханамжийн байдал	
	4. Тогтвортой хөгжлийг таниулах, хэрэгжилтэнд хувь нэмэр оруулах, бодлогын бичиг баримт боловсруулахад санал	Мэргэжлийн холбоодтой хамтарч ажилласан байдал	Ажлын тайлан	Ажлын тоо, чанар, хүртээмж	

	дэвшүүлэх				
	5. Өөрийн мэдлэг чадварыг тасралтгүй хөгжүүлэх, мэргэжлийн үйл ажиллагаа руу чиглүүлэх	Салбарын тогтвортой хөгжилд оруулсан хувь нэмэр	Холбогдох байгууллагын нотолсон баримт	Ажлын чанар, хүртээмж	
	6. Мэргэжлийн чиглэлээр сургалт зохион байгуулах	Салбарын тогтвортой хөгжилд оруулсан хувь нэмэр	Холбогдох байгууллагын нотолсон баримт	Ажлын чанар, хүртээмж	
	7. Суралцагчид болон олон нийтэд зориулсан мэргэжлийн онол-арга зүйн зөвлөмж мэдээлэл бэлтгэх, ажлын арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх	Зохион байгуулсан ажлуудын үүрэг, ач холбогдол	Зохион байгуулсан ажлуудын тайлан, мэдээлэл	Зохион байгуулсан ажлын тоо, үр өгөөж Оролцогчдын сэтгэл ханамжийн түвшин	
	8. Судалгааны ажлын үр дүн болон шинжлэх ухааны мэдлэгийг мэргэжлийн салбар, холбоод, төгсөгчид, ажил олгогчдын захиалгаар түгээн дэлгэрүүлэх үйлд санаачлагатай оролцох	Зохион байгуулсан сургалтын оновчтой байдал	Зохион байгуулсан ажлуудын тайлан, мэдээлэл	Зохион байгуулсан ажлын тоо, үр өгөөж Оролцогчдын сэтгэл ханамжийн түвшин	
	9. Үйлдвэрлэл, ажлын байран дээр тулгарч буй асуудлыг мэргэжлийн зүгээс шийдвэрлэх үйл ажиллагаанд оролцох	Зохион байгуулсан сайн дурын ажил	Ажлын тайлан	Ажлын чанар, хүртээмж Оролцогчдын сэтгэл ханамжийн түвшин	
Ахлах багш	1. Иргэдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалтыг зохион байгуулах	Зохион байгуулсан сургалтын оновчтой байдал	Зохион байгуулсан ажлуудын тайлан, мэдээлэл	Зохион байгуулсан ажлын тоо, үр өгөөж Оролцогчдын сэтгэл ханамжийн түвшин	
	2. Сургалтын болон салбар, мэргэжлийн хүрээний дүрэм, журам, санал, зөвлөмж, норм норматив, стандарт, арга зүй, аргачлал боловсруулах ажилд идэвхитэй оролцох, боловсруулах, түгээх ажилд санаачлагаараа оролцох	Зохион байгуулсан ажлуудын үүрэг, ач холбогдол	Зохион байгуулсан ажлуудын тайлан, мэдээлэл	Зохион байгуулсан ажлуудын тоо, үр өгөөж Оролцогчдын сэтгэл ханамжийн түвшин	
	3. Тогтвортой хөгжлийг таниулах, хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах	Энэ чиглэлийн ажлын арга туршлага эзэмшсэн байдал	Боловсруулалтад нь оролцсон бүтээгдэхүүнүүд	Бүтээгдэхүүнүүдийн боловсруулалтын чанар	
	4. Нийгмийг соён гэгээрүүлэх, нийгмийн сайн сайхны төлөө сайн дурын үйл ажиллагаанд оролцох	Хамтын ажиллагаанд оролцсон байдал, гүйцэтгэсэн үүрэг	Оролцсон ажлын тайлан, мэдээлэл	Ажлын тоо, чанар, хүртээмж Хамтран ажиллагчдын түүний оролцооны талаарх үнэлгээ	
	5. Иргэдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн мэргэжлийн үйлчилгээ, сургалтыг зохион байгуулах	Зохион байгуулсан сургалтын оновчтой байдал	Зохион байгуулсан ажлуудын тайлан, мэдээлэл	Зохион байгуулсан ажлын тоо, үр өгөөж Оролцогчдын сэтгэл ханамжийн түвшин	
	6. Сургалтын болон салбар, мэргэжлийн хүрээний дүрэм, журам, санал, зөвлөмж, норм норматив, стандарт, арга зүй, аргачлал боловсруулах ажилд идэвхитэй оролцох, боловсруулах, түгээх	Зохион байгуулсан сургалтын оновчтой байдал	Зохион байгуулсан ажлуудын тайлан, мэдээлэл	Зохион байгуулсан ажлын тоо, үр өгөөж Оролцогчдын сэтгэл ханамжийн түвшин	
	7. Мэргэжлийн холбоод, салбар мэргэжилтэнүүдийн хоорондын хамтын ажиллагаанд идэвхитэй оролцох	Салбарын тогтвортой хөгжилд оруулсан хувь нэмэр	Оролцсон ажлуудын тухай тайлан мэдээлэл	Ажлын чанар, хүртээмж	
	8. Үйлдвэрлэл, ажлын байран дээр тулгарч буй асуудлыг мэргэжлийн зүгээс шийдвэрлэх үйл ажиллагаанд оролцох	Зохион байгуулсан сайн дурын ажил	Оролцсон ажлын тайлан, мэдээлэл	Ажлын чанар, хүртээмж Оролцогчдын сэтгэл ханамжийн түвшин	
Дэд профессор	1. Боловсрол, ажил мэргэжлийн салбарын хүрээнд мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулах ажиллагаанд оролцох	Сургалтын ач холбогдол	Сургалтын хөтөлбөр, холбогдох бичиг баримт	Зохион байгуулсан сургалтын тоо, үр өгөөж Оролцогчдын сэтгэл ханамжийн түвшин	
	2. Салбарын хөтөлбөрийн чанарыг баталгаажуулах, магадлан итгэмжлэх үйл ажиллагааг манлайлан, удирдах	Тухайн чиглэлийн ажлын арга туршлага эзэмшсэн байдал	Оролцсон бүтээгдэхүүн	Бүтээгдэхүүнүүдийн боловсруулалтын чанар Хамтран ажиллагчдын түүний оролцооны талаарх үнэлгээ	
	3. Их сургууль, үйлдвэр, аж ахуйн газрын хамтын ажиллагааг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах, манлайлах	Мэргэжлийн холбоодтой хамтарч ажилласан байдал	Ажлын тайлан	Ажлын тоо, чанар, хүртээмж Хамтран ажиллагчдын түүний оролцооны	

				талаарх үнэлгээ	
	4. Залуу багш нар, судлаачдыг дэмжин ажиллах, тэднийг чиглүүлэх	Редакц, мэргэжлийн зөвлөлд ажилласан байдал	Сэтгүүлийн редакц, мэргэжлийн зөвлөлийн ажлын тайлан	Ажилласан редакцын зөвлөл, мэргэжлийн зөвлөлийн тоо, оролцоо Сэтгүүлийн чанар, хүртээмж	
	5. Боловсрол, ажил мэргэжлийн салбарын хүрээнд мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх	Магадлан итгэмжлэлд оролцсон байдал	Магадлан итгэмжлэлийн тайлан	Магадлан итгэмжилсэн хөтөлбөрийн тоо, итгэмжлэгдсэн байдал	
	6. Үндэсний болон салбар, мэргэжлийн хүрээний дүрэм, журам, санал, зөвлөмж, норм, стандарт, арга зүй, аргачлал, тайлан боловсруулах, түгээх, нийтийн хүртээл болгох ажлыг манлайлах	Салбарын тогтвортой хөгжилд оруулсан хувь нэмэр	Оролцсон ажлуудын тухай тайлан мэдээлэл	Ажлын чанар, хүртээмж	
	7. Сургалтын үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр ажил олгогч, салбар мэргэжлийн түншлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Салбарын тогтвортой хөгжилд оруулсан хувь нэмэр	Оролцсон ажлуудын тухай тайлан мэдээлэл	Ажлын чанар, хүртээмж	
	8. Мэргэжлийн холбоод салбарын хооронд хамтын ажиллагаанд идэвхитэй манлайлан оролцох	Зохион байгуулсан сайн дурын ажил	Ажлын тайлан	Ажлын чанар, хүртээмж Оролцогчдын сэтгэл ханамжийн түвшин	
	9. Үйлдвэрлэл, ажлын байран дээр тулгарч буй асуудлыг мэргэжлийн зүгээс шийдвэрлэх үйл ажиллагааг удирдах, зохион байгуулах, манлайлах	Салбарын тогтвортой хөгжилд оруулсан хувь нэмэр	Оролцсон ажлуудын тухай тайлан мэдээлэл	Ажлын чанар, хүртээмж	
Профессор	1. Үндэсний хэмжээнд болон салбар, мэргэжлийн хүрээний бодлогыг боловсруулах, харьцуулсан анализ хийж үнэлэлт дүгнэлт гаргах, инновацийг бий болгох, хөгжүүлэх арга замыг тодорхойлох	Энэ чиглэлийн ажлын арга туршлага эзэмшсэн байдал	Боловсруулсан бүтээгдэхүүнүүд	Боловсруулалтын чанар Бүтээгдэхүүний хэрэгжилт	
	2. Боловсрол ажил мэргэжлийн салбарын хүрээнд мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулах	Энэ чиглэлийн судалгааны ажлын арга барил эзэмшсэн байдал	Судалгааны ажлын тайлан, мэдээлэл	Бүтээгдэхүүнүүдийн боловсруулалтын чанар Хамтран ажиллагчдын түүний оролцооны талаарх үнэлгээ	
	3. Мэргэжлийн холбоод салбарын хооронд хамтын ажиллагаанд оролцох	Санаачлан боловсруулсан сургалтын хөтөлбөр	Хөтөлбөрийн баримт бичиг	Зохион байгуулсан сургалтын тоо / үр өгөөж Оролцогчдын сэтгэл ханамжийн түвшин	
	4. Мэргэжлийн эрдэм шинжилгээний сэтгүүлийг хөгжүүлэх редакц, мэргэжлийн зөвлөлд ажиллах	Мэргэжлийн холбоодтой хамтарч ажилласан байдал	Оролцсон ажлын тайлан	Ажлын тоо, чанар, хүртээмж Хамтран ажиллагчдын сэтгэл ханамжийн түвшин	
	5. Салбарын хөтөлбөрийн чанарыг баталгаажуулах, магадлан итгэмжлэх үйл ажиллагаанд манлайлан идэвхийлэн оролцох	Редакц, мэргэжлийн зөвлөлд ажилласан байдал	Сэтгүүлийн редакц, мэргэжлийн зөвлөлийн ажлын тайлан	Ажилласан редакцын зөвлөл, мэргэжлийн зөвлөлийн тоо, оролцоо Сэтгүүлийн чанар, хүртээмж	
	6. Тогтвортой хөгжлийг таниулах, хэрэгжүүлэх	Магадлан итгэмжлэлд оролцсон байдал	Магадлан итгэмжлэлийн тайлан	Магадлан итгэмжилсэн хөтөлбөрийн тоо Итгэмжлэгдсэн байдал	
	7. Нийгмийг соён гэгээрүүлэх, нийгмийн сайн сайхны төлөө үйл ажиллагаанд оролцох	Салбарын тогтвортой хөгжилд оруулсан хувь нэмэр	Оролцсон ажлуудын тухай тайлан мэдээлэл	Ажлын чанар, хүртээмж	
	8. Суралцагчид болон олон нийтэд зориулсан мэргэжлийн онол-арга зүйн зөвлөмж мэдээлэл бэлтгэх, ажлын арга зүйн зөвлөгөө өгөх	Салбарын тогтвортой хөгжилд оруулсан хувь нэмэр	Оролцсон ажлуудын тухай тайлан мэдээлэл	Ажлын чанар, хүртээмж	

9. Судалгааны ажлын үр дүн болон шинжлэх ухааны мэдлэгийг мэргэжлийн салбар, холбоод, төгсөгчид, ажил олгогчдын захиалгаар түгээн дэлгэрүүлэх үйл хийх	Салбарын тогтвортой хөгжилд оруулсан хувь нэмэр	Оролцсон ажлуудын тухай тайлан мэдээлэл	Ажлын чанар, хүртээмж	
10. Үйлдвэрлэл, ажлын байран дээр тулгарч буй асуудлуудыг мэргэжлийн зүгээс шийдвэрлэх, үйл ажиллагааг зохион байгуулах, удирдах	Салбарын тогтвортой хөгжилд оруулсан хувь нэмэр	Оролцсон ажлуудын тухай тайлан мэдээлэл	Ажлын чанар, хүртээмж	
11. Залуу багш нар, судлаачдыг дэмжин ажиллах, тэднийг чиглүүлэх	Салбарын тогтвортой хөгжилд оруулсан хувь нэмэр	Оролцсон ажлуудын тухай тайлан мэдээлэл	Ажлын чанар, хүртээмж	
12. Үндэсний болон салбар, мэргэжлийн хүрээний дүрэм, журам, санал, зөвлөмж, норм, стандарт, арга зүй, аргачлал, тайлан боловсруулах, түгээх, нийтийн хүртээл болгох ажлыг манлайлах	Салбарын тогтвортой хөгжилд оруулсан хувь нэмэр	Оролцсон ажлуудын тухай тайлан мэдээлэл	Ажлын чанар, хүртээмж	
13. Сургалтын үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр ажил олгогч, салбар мэргэжлийн түншлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх Мэргэжлийн холбоод салбарын хоорондын хамтын ажиллагаанд идэвхитэй манлайлан оролцох	Зохион байгуулсан сайн дурын ажил	Ажлын тайлан	Ажлын чанар, хүртээмж Оролцогчдын сэтгэл ханамжийн түвшин	

ШУТИС-ИЙН БАГШИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НИЙТЛЭГ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

ШУТИС-ийн багшийн албан тушаалын бүх зэрэглэлд ажиллаж байгаа багш (цаашид профессор багш гэх) нарын сургалт, судалгаа-инновац, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний үйл ажиллагаа болон түүний чанарыг (цаашид “үйл ажиллагаа” гэх) үнэлэхэд энэхүү журмыг баримтална.

Профессор багшийн үйл ажиллагааны үнэлгээний зорилго нь тэднийг ажлын байран дээрээ хөгжих боломжоор хангах, профессор багшийн хөгжлийг дэмжсэнээр дээд боловсролын сургалт, судалгаа, үйлчилгээний чанар, үр өгөөжийг дээшлүүлэхэд оршино.

Энэхүү журмыг их сургууль, дээд сургууль, коллеж бүр өөрийн үйл ажиллагааны онцлог, хөгжлийн бодлого, стратегид нийцүүлэн профессор багшийн үйл ажиллагааг үнэлэхдээ үндэслэл болгоно.

Профессор багшийн үйл ажиллагааны үнэлгээний журам нь Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд нийцсэн байна.

Хоёр. Профессор багшийн үнэлгээний тогтолцоо

2.1. Профессор багшийн үйл ажиллагааны үнэлгээ нь өөрийн үнэлгээнд суурилсан олон талын оролцоотой цогц үнэлгээ байна.

2.2. Профессор багшийн үйл ажиллагааны үнэлэх процесс нь профессор багшийн өөрийн үнэлгээ, салбар нэгжийн хамтын үнэлгээ, сургуулийн түвшний хөндлөнгийн үнэлгээ гэсэн шатлалтай байна.

2.3. Профессор багшийн өөрийн үнэлгээ гэдэгт албан тушаалын зэрэглэл болон ажлын байрны тодорхойлолтод нийцүүлэн профессор багшид тавигдах нийтлэг шаардлага, үнэлгээний шалгуурын дагуу үйл ажиллагаандаа үнэлгээ өгч, өөрийн үнэлгээний тайлангаа салбар нэгжээр хэлэлцүүлж, үнэлгээний үр дүнг хөгжлийн төлөвлөгөөндөө тусгаж ажиллахыг ойлгоно.

2.4. Салбар нэгжийн хамтын үнэлгээ гэдэгт салбар нэгжийн түвшинд профессор багш нэг бүртэй өөрийн үнэлгээний шалгуурыг хэлэлцэн тохиролцсоны үндсэн дээр профессор багшийн өөрийн үнэлгээний тайланг хэлэлцэн үнэлж, үнэлгээний үр дүнд үндэслэн салбар нэгжээс профессор багшид өөрийгөө хөгжүүлэх талаар зөвлөгөө өгөх ба түүнд хөгжлийн төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэхийг ойлгоно.

2.5. Сургуулийн түвшинд хөндлөнгийн үнэлгээ гэдэгт сургалт болон чанарын баталгаажуулалтын асуудал хариуцсан нэгж эсвэл сургуулийн удирдлагаас шаардлагатай тохиолдолд профессор багшийн үйл ажиллагаа, мөн өмнөх шатны үнэлгээнд чанарын үнэлгээ хийх ажлын хэсгийг томилон ажиллуулах бөгөөд үнэлгээний үр дүнд үндэслэн тухайн профессор багшийн хөгжлийг дэмжиж ажиллахыг ойлгоно.

2.6. Сургуулийн түвшний хөндлөнгийн үнэлгээнд боловсролын болон мэргэжлийн

байгууллагууд, ажил олгогчид, боловсролын үйлчилгээ хүртэгчдийн хараат бус төлөөллийг татан оролцуулж болно.

2.7. Профессор багшийн үйл ажиллагааны үнэлгээ нь оролцогч талуудын хамтын ажиллагаанд түшиглэсэн, үр дүнд чиглэсэн, тасралтгүй явагдах процесс бөгөөд их сургууль, дээд сургууль, коллежийн чанарын дотоод баталгаажуулалтын нэг бүрэлдэхүүн хэсэг юм.

Гурав. Профессор багшийн үйл ажиллагааг үнэлэх

3.1. Профессор багшийн үйл ажиллагааг сургалт, судалгаа, инновац, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээ гэсэн таван үндсэн чиглэлээр хичээлийн жил тутамд нэгээс цөөнгүй удаа үнэлнэ.

3.2. Профессор багшийн үйл ажиллагааг үнэлэх үнэлгээний шалгуур нь “Их сургууль, дээд сургууль, коллежийн багшид тавигдах нийтлэг шаардлага”-д нийцсэн байна.

3.3. Их сургууль, дээд сургууль, коллеж нь профессор багшийн үйл ажиллагааг үнэлэхдээ энэ журмын нэгдүгээр хавсралтаар баталсан “Профессор багшийн үйл ажиллагааны үнэлгээний шалгуур, үнэлэх үзүүлэлт”-ийг өөрийн онцлогтоо нийцүүлэн тухайн мэргэжилд тохируулан ашиглана. Сургууль бүр профессор багшийн үйл ажиллагааг үнэлэх журамтай байна.

3.4. Профессор багшийн үйл ажиллагааг нотлох баримтад үндэслэн тоон болон чанарын үзүүлэлтээр үнэлнэ.

3.5. Профессор багшийн үйл ажиллагааны үнэлгээ нь олон талын оролцоог хангасан байх бөгөөд үнэлгээнд оролцогч талууд энэ журмын хоёрдугаар хавсралтаар баталсан “Профессор багшийн үйл ажиллагаанд үнэлгээ хийх ерөнхий аргачлал”-ын дагуу ажиллана.

3.6. Нийт үнэлгээнд энэ журмын 3.1-д заасан үйл ажиллагааны чиглэл тус бүрийн үнэлгээний эзлэх хувийг профессор багшийн албан тушаалын зэрэглэл болон тухайн сургуулийн үйл ажиллагааны чиглэл, онцлогт нийцүүлэн тогтооно.

3.7. Профессор багшийн үйл ажиллагааг үнэлэхдээ тухайн үйл ажиллагаатай холбоотой оюутан суралцагчийн болон хамтран ажиллагсад, үйлчилгээ хүртэгчдийн сэтгэл ханамжийн судалгааны дүнг харгалзан үзнэ.

Дөрөв. Профессор багшийн үйл ажиллагааны үнэлгээний үр дүнг хэрэгжүүлэх

4.1. Профессор багш нь түүний өөрийн үнэлгээний тайланд үндэслэн хийсэн салбар нэгжийн хамтын үнэлгээ болон сургуулийн түвшний хөндлөнгийн үнэлгээний үр дүнд түүнд өгсөн зөвлөгөөг үйл ажиллагаагаа сайжруулахад бүтээлчээр ашиглаж, өөрийн хөгжлийн төлөвлөгөөндөө тодорхой зорилт дэвшүүлж, хэрэгжүүлж ажиллана.

4.2. Салбар нэгжийн түвшинд профессор багшийн үйл ажиллагааны үнэлгээнд ажил хэрэгч хандаж, профессор багшид ажлын байран дээрээ өөрийгөө хөгжүүлэх боломжийг бүрдүүлэн түүнийг дэмжиж ажиллана.

4.3. Сургуулийн түвшинд профессор багшийн үйл ажиллагааны үнэлгээний дүнд үндэслэн профессор багшийн хөгжлийн дэмжих арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

4.4. Профессор багшийн үйл ажиллагааны үнэлгээнд оролцогч бүх талууд үнэлгээний явцад харилцан туршлага солилцох, сайн туршлагыг дэлгэрүүлэх, зөвлөн туслах зэргээр дотоод хамтын ажиллагааг хөгжүүлж ажиллана.

4.5. Их сургууль, дээд сургууль, коллеж нь профессор багш нарын хөгжлийг дэмжих, энэ чиглэлээр салбар нэгжээс хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, түүний үр өгөөжид хяналт тавьж, зөвлөн туслах, мөн хамтран ажиллах үүрэг бүхий дотоод бүтцийн нэгжтэй байна.

Тав. Бусад

5.1. Бүх шатны үнэлгээний үнэн бодитой, үр өгөөжтэй байдлыг үнэлгээ хийж байгаа этгээд хариуцна.

5.2. Профессор багшийн үйл ажиллагааны үнэлгээтэй холбоотой маргаан үүсвэл үнэлгээнд оролцогч талууд сургуулийн удирдлагад бичгээр өргөдөл, гомдол гаргаж болно. Түүнийг тухай байгууллагын дотоод журам, ёс зүйн дүрмийн дагуу шийдвэрлэнэ.

--- оОо ---

ПРОФЕССОР БАГШИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЕРӨНХИЙ АРГАЧЛАЛ

Профессор багшийн үйл ажиллагааг сургалт, судалгаа инновац, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээ гэсэн гурван чиглэлээр үнэлнэ. Үнэлгээ нь олон талын оролцоог хангасан тасралтгүй явагдах цогц үйл ажиллагаа байна.

Профессор багшийн үйл ажиллагааны үнэлгээний тогтолцоо нь гурван шатлалтай байна. Үүнд:

1. Профессор багшийн өөрийн үнэлгээ
2. Салбар нэгжийн хамтын үнэлгээ
3. Сургуулийн түвшний хөндлөнгийн үнэлгээ

Үнэлгээг профессор багш бүр хичээлийн жил тутамд нэгээс цөөнгүй удаа хийнэ.

Профессор багш нь өөрийн үнэлгээний хүрээнд дараах ажлуудыг хариуцан гүйцэтгэнэ:

- Албан тушаалын шатлал, ажлын байрны тодорхойлолт болон профессор багшид тавигдах нийтлэг шаардлагад үндэслэн өөрийн үндсэн үүрэгт ажлын жагсаалт гаргана.
- Үндсэн үүрэгт ажил бүрийн үр дүнг үнэлэх шалгуурыг өөрийн хариуцсан ажлын онцлогтой нягт уялдуулан профессор багшийн үйл ажиллагааны үнэлгээний шалгуурын дагуу тодорхойлно.
- Үүрэгт ажлын жагсаалт болон үнэлгээний шалгуурыг салбар нэгжээр хэлэлцүүлж батлуулна.
- Батлагдсан шалгуурын дагуу өөрийнхөө ажилд үнэлгээ өгч, өөрийн үнэлгээний тайлан бичнэ.
- Өөрийн үнэлгээний тайлангаа салбар нэгжээр хэлэлцүүлж, үнэлүүлэн зөвлөгөө авна.
- Өөрийн үнэлгээний үр дүнд тулгуурлан хөгжлийн төлөвлөгөөндөө тодорхой зорилт дэвшүүлж, хэрэгжүүлж ажиллана.

Салбар нэгжийн хамтын үнэлгээний хүрээнд тухайн нэгжээс дараах ажлуудыг хариуцан гүйцэтгэнэ:

- Профессор багш бүрийн үйл ажиллагааны өөрийн үнэлгээний шалгуурыг хэлэлцэн батална.
- Профессор багшийн үйл ажиллагаанд 2-3 багшаар мэргэжил нэгтнээр үнэлгээ хийлгэнэ.
- Профессор багшийн өөрийн үнэлгээний тайлан болоод мэргэжил нэгтний үнэлгээний дүнг харьцуулан үзэж, тэдний ажлын арга барил, хандлага, мэдлэг, чадварт дүгнэлт гаргана.

- Салбар нэгжийн хамтын үнэлгээний үр дүнд үндэслэн тухайн профессор багшид өөрийгөө хөгжүүлэх талаар зөвлөгөө өгч, хөгжлийн төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлнэ.

Сургуулийн түвшний хөндлөнгийн үнэлгээний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ:

- Хөндлөнгийн үнэлгээний ажлыг жил, улирлаар төлөвлөнө.
- Дээрх хоёр шатлалын үнэлгээгээр хангалтгүй болон нийцэлгүй үнэлэгдсэн профессор багшийг сургуулийн түвшний хөндлөнгийн үнэлгээнд хамруулна.
- Сургалт болон чанарын баталгаажуулалт хариуцсан нэгж эсвэл сургуулийн удирдлага үнэлгээний ажлын хэсгийг томилон ажиллуулна.
- Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тухайн профессор багшийн үйл ажиллагаатай хамаарал бүхий мэргэжлийн байгууллага, ажил олгогчид, боловсролын үйлчилгээ хүртэгчдийн төлөөллийг оролцуулж болно.
- Үнэлгээнд хамрагдсан профессор багшийн бүх шатлалын үнэлгээний үр дүнг харьцуулан үзэж, үнэлгээний чанарт дүгнэлт гаргана. Дүгнэлтийг сургуулийн удирдлагад танилцуулна.
- Салбар нэгж болон профессор багшид үйл ажиллагаагаа сайжруулах зөвлөгөө, даалгавар өгч профессор багшийн хөгжлийг дэмжих арга хэмжээ авч ажиллана.

Профессор багшийн үйл ажиллагааны үнэлгээнд дараах зарчмыг баримтална:

- Өөрийн үнэлгээнд суурилах
- Олон талын оролцоог хангах
- Нэгдсэн ойлголт, эерэг хандлагатай байх
- Хамтын ажиллагааг эрхэмлэх
- Багшийн хөгжлийг дэмжих

--- оОо ---